



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ




Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2020 • IX • № 49

Б.ЛХАГВАСҮРЭН:
ТӨВ БАНК ЗЭЭЛИЙН
ТАСАЛДАЛ
ҮҮСГЭХГҮЙ БАЙХ,
ХҮҮГ БУУРУУЛАХЫГ
ЗОРЬЖ БАЙНА

ДЭЛХИЙ НИЙТИЙН
ЦАР ТАХАЛТАЙ
ХИЙЖ БУЙ ТЭМЦЭЛ:
МӨНГӨНИЙ
БОДЛОГЫН
ШИЙДВЭРҮҮД

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС:
ТИЙН ЯЛСАН СУВАРГА



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Бодлогын хүүг бууруулах, урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгсэл нэвтрүүлэх тухай

Дугаар: 2020/05

Огноо: 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр хуралдан (1) бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 8 хувьд хүргэх; (2) урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх шийдвэр гаргалаа. Энэхүү шийдвэр нь эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан үзээд банкны салбараас эдийн засгийн бодит секторт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн болно. Тухайн шийдвэр, арга хэмжээ нь инфляцын зорилтыг хангаж, эдийн засгийн уналтыг сааруулан, улмаар сэргэлтийг дэмжинэ.

Жилийн инфляц 2020 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 2.1 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 1.7 хувьд хүрч буурав. Ирэх саруудад инфляц суурь үеийн нөлөөгөөр бага зэрэг нэмэгдэх хэдий ч, өнөөгийн бага түвшинд хадгалагдаж, ирэх жилүүдэд зорилтот түвшнээс давахааргүй байна. Эдийн засаг "КОВИД-19" цар тахлын нөлөөгөөр 2020 оны эхний хагаст 9.7 хувиар агшсан нь сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд тохиолдоогүй, хүлээлтээс давсан огцом уналт боллоо. Гэхдээ мөнгөний болон сангийн бодлогын арга хэмжээнүүд, гадаад орчны сэргэлттэй холбоотойгоор энэ оны сүүлийн хагаст эдийн засгийн уналт саармагжиж, ирэх онд сэргэх төлөвт шилжихээр байна.

"КОВИД-19" цар тахлын нөлөөгөөр глобал эдийн засгийн идэвхжил энэ оны эхний хагас жилд огцом унасны дараа хоёрдугаар хагасаас тогтвортой бус байгаа ч сайжрах төлөвтэй байгаа. Энэ нь хөрөнгийн захын үнэ, эрдэс бүтээгдэхүүний үнэ, худалдааны идэвхжил зэргээс харагдаж байна. Гэвч гадаад, дотоод эдийн засгийн цаашдын төлөв нь вирусийн тархалтыг хяналтандаа оруулахаас хамаарч байгаа тул тодорхой бус байдал өндөр хэвээр байна. "КОВИД-19" цар тахлын нөлөөг бууруулах зорилгоор шат дараатай авч хэрэгжүүлж буй мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээнүүд нь дотоод эдийн засгийн уналтыг сааруулах, банкны салбарын тогтвортой байдлыг хадгалахад дэмжлэг үзүүлж байна. Цаашид ч банк, өрх, аж ахуйн нэгжийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжихийн зэрэгцээ банкны системийн зээлийн тасалдал үүсэхээс сэргийлсэн арга хэмжээнүүдийг авч ажиллана.

Мөнгөний бодлогын хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО



04

ОНЦЛОХ МЭДЭЭ

МОНГОЛБАНК
ХАРИЛЦАА ХОЛБОО,
МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН
ГАЗАРТАЙ ХАМТРАН
АЖИЛЛАНА



23

МОНГОЛБАНК ЮУ ХИЙДЭГ ВЭ?


Ц.МӨНХБАЯР:
МӨНГӨНИЙ БОДЛОГЫН
ХОРОО УРАГШАА
ХАРСАН ШИЙДВЭР
ГАРГАХЫГ ЗОРЬДОГ



06

ЯРИЛЦЛАГА

Б.ЛХАГВАСҮРЭН:
ТӨВ БАНК ЗЭЭЛИЙН
ТАСАЛДАЛ ҮҮСГЭХГҮЙ
БАЙХ, ХҮҮГ
БУУРУУЛАХЫГ ЗОРЬЖ
БАЙНА



18

НИЙТЛЭЛ

ГАДААДЫН ШУУД
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ
ШААРДЛАГАТАЙ
САЛБАРТ, ЗӨВ
БОДЛОГООР ТАТАХ НЬ
ЧУХАЛ



28

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ


ДЭЛХИЙ НИЙТИЙН
ЦАР ТАХАЛТАЙ
ХИЙЖ БУЙ ТЭМЦЭЛ:
МӨНГӨНИЙ БОДЛОГЫН
ШИЙДВЭРҮҮД



21

МОНГОЛБАНКНЫ МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛБАНК 9 ДҮГЭЭР
САРД 2.3 ТОНН ҮНЭТ
МЕТАЛЛ ХУДАЛДАН
АВЛАА



32

БАНКИР

ЖИЙН-ПАСКАЛ: ХҮНИЙ
БОЛОН ИНСТИТУЦИЙН
КАПИТАЛАА
ТӨРӨЛЖҮҮЛЖ
ЧАДААГҮЙ НЬ
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
БОЛОН ЭКСПОРТЫН
ТӨРӨЛЖИЛТ СУЛ БАЙХ
ГОЛ ШАЛТГААН БОЛЖ
БАЙНА

35

СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

ИРГЭДИЙН
САНХҮҮГИЙН СУУРЬ
МЭДЛЭГИЙН ӨНӨӨГИЙН
БАЙДАЛ

2020.09.03

МОНГОЛБАНК ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛАНА

Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээг цахимжуулах “E Mongolia” хөтөлбөрийн хүрээнд Монголбанк болон Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар хамтран ажиллахаар боллоо. Уг хамтын ажиллагааны хүрээнд төрийн үйлчилгээний төлбөр тооцоог Монголбанкаар дамжуулан түргэн шуурхай, зардал чирэгдэлгүйгээр гүйцэтгэх боломжтой болж байна. Засгийн газар, ХХМТГ-аас өнгөрсөн хугацаанд иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлсэн ч үйлчилгээний төлбөр тооцоог цахимаар гүйцэтгэх боломжгүй иргэд заавал банкны салбараар үйлчлүүлэх шаардлагатай байсан нь хүндрэл үүсгэж байсан юм. Үүнийг шийдвэрлэхийн тулд “E Mongolia” цахим системд Монголбанк нэгдсэнээр 180 орчим төрийн үйлчилгээний төлбөр, тооцоог Монголбанкаар дамжуулан бодит цагийн горимоор гүйцэтгэх бүрэн боломжтой болж байна.

2020.09.04

ЗАЛУУЧУУДЫН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛАВ

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд Монголбанк төрийн бусад байгууллагуудтай хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг 2016 онд батлан, хэрэгжүүлж байгаа билээ. Тус хөтөлбөр нь хүүхэд, залуус санхүүгийн зах зээлд ухаалгаар оролцох оролцоог нэмэгдүүлэх, оновчтой шийдвэр гаргалтыг дээшлүүлэх зорилготой. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Монголбанк залуучуудад санхүүгийн боловсрол олгох зорилтот үйл ажиллагааг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран хэрэгжүүлэхээр санамж бичигт гарын үсэг зурлаа. Талуудын хамтын ажиллагааны үр дүнд залуучуудын санхүүгийн мэдлэгийг дээшлүүлснээр тэдний санхүүгийн зохистой шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэх, хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалт хийх мэдлэг, чадварыг дэмжих шинэ боломжийг бий болгох юм.

2020.09.08

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА


Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гуравдугаар улирлын ээлжит хуралдаанаар “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах Үндсэн чиглэлийн төсөл, тооцоо судалгаа”, “Үнэт цаасны хадгаламжийн төв болон Төв банкны арилжааны нэгдсэн системийг нэвтрүүлэх ажлын хэрэгжилт” гэсэн асуудлуудыг хэлэлцэж, санал солилцлоо. Мөн хуралдаанаар “Засгийн газрын дотоод үнэт цаас гаргах”, “Зээлжих зэрэглэлийн талаар” танилцуулга сонсож, “Санхүүгийн хүртээмжийг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн төслийн тухай тус тус хэлэлцэв. Хуралдааныг СЗХ-ны дарга Д.Баярсайхан даргалж, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, ХДК-ийн гүйцэтгэх захирал Х.Бум-Эрдэнэ болон бусад холбогдох албан тушаалтнууд оролцлоо.

2020.09.14

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДАЖ ХУРЛЫН ШИЙДВЭРЭЭ ТАНИЛЦУУЛАВ

Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурлаар Монголбанкны Эрсдэлийн удирдлагын албаны үйл ажиллагааны талаар тус албаны захирал Д.Баянзулын мэдээллийг сонсов. Мөн Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар тус албаны захирал С.Ганбаярын мэдээлэлтэй танилцан холбогдох дүгнэлт, зөвлөмжийг өглөө. Түүнчлэн Монгол Улсын гадаад өр, төлбөрийг барагдуулж буй үйл явцтай танилцаж, цаашид судалгаан дээр тулгуурлаж, бодит тоо баримтыг үндэслэн олон нийтийг мэдээллээр хангах талаар хэрхэн хамтран ажиллах, бодлогын баримт бичиг боловсруулах талаар санал солилцлоо.

2020.09.22

МОНГОЛБАНК СУДАЛГААНЫ МАГИСТРЫН ТҮВШИНД СУРАЛЦАХ 10 ОЮУТАНД ТЭТГЭЛЭГ ОЛГОНО

Монголбанкны эдийн засаг, санхүүгийн чиглэлийн судалгаа, сургалтыг дэмжих “Тинк банк” хөтөлбөрийн хүрээнд МУИС-тай хамтын ажиллагааны гэрээ байгууллаа. Энэхүү хөтөлбөр нь эдийн засаг, санхүүгийн чиглэлээр судалгааны магистрын түвшинд суралцаж буй оюутнуудын судалгааны чанарыг сайжруулах, Монголбанкны болон хөндлөнгийн судлаач нарын хамтын ажиллагааг ахиулах, судлаач нарын бүтээлийг олон нийтэд түгээх, бодлого боловсруулахад оролцох оролцоог нь нэмэгдүүлэх зорилготой. Талууд гэрээний хүрээнд “Монголбанкны Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг”-ийг эдийн засаг болон санхүүгийн чиглэлээр судалгааны магистрт суралцах нийт 10 оюутанд олгох бөгөөд бүтэн цагаар суралцаж, судалгаа хийх боломжийг олгоно. Тэтгэлгийн өрсөлдөөнт сонгон шалгаруулалтыг Монголбанк, МУИС хамтран хийж, шилдэг оюутнуудыг хамруулахаар зорьж байна.

2020.09.23

МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБООНЫ ДЭРГЭД САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАГЧ БАГШ НАРЫГ БЭЛТГЭЛЭЭ

“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын эмэгтэйчүүдийн холбоо хамтран санхүүгийн боловсрол олгох сургагч багш бэлтгэх сургалтыг 9-р сарын 21, 22-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус сургалтаар Монголын эмэгтэйчүүдийн холбооны аймаг, Нийслэлийн салбар зөвлөлийн 9 дүүргээс нийтдээ 30 хүн хамрагдав. Энэхүү сургалтаар хувийн санхүүгээ удирдах, өрхийн төсөв хөтлөх чадварыг дээшлүүлж, мөнгөний үнэ цэнэ, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх ойлголтуудыг өгч, сургалт орох арга зүйг заан, сургагч багш нарыг бэлтгэлээ. Бэлтгэгдсэн сургагч багш нар нь “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж, дүүрэг, аймгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох сургалтыг түгээж байх юм.

2020.09.25

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2021 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙГ УИХ-Д ӨРГӨН БАРИВ

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах Үндсэн чиглэлийн төслийг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн УИХ-ын дарга Г.Занданшатарт өргөн барилаа. Уг төсөлд тусгаснаар Монголбанк инфляцыг 2021-2023 онуудад ± 2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулахыг зорино. Үүний зэрэгцээ цар тахлаас шалтгаалан эдийн засгийн төлөв, санхүүгийн орчинд бий болсон сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, банкны системийн эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн зуучлалыг тасалдуулахгүй байлгах зорилгоор макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ. Санхүүгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд “Ковид-19” цар тахлын эдийн засгийн хүндрэлийн үед мөчлөг сөрсөн арга хэрэгслийг ашиглан банкны салбарын эрсдэл даах чадварыг хадгалах, хяналт шалгалтын болон зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, хууль эрх зүйн орчны шинэтгэлийг үргэлжлүүлэхээр тусгав.



Б.ЛХАГВАСҮРЭН: ТӨВ БАНК ЗЭЭЛИЙН ТАСАЛДАЛ ҮҮСГЭХГҮЙ БАЙХ, ХҮҮГ БУУРУУЛАХЫГ ЗОРЬЖ БАЙНА

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнтэй Мөнгөний бодлогын хорооны 9-р сарын хурлын шийдвэр (Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 8% болгохын зэрэгцээ Төв банк урт хугацаат репо хэрэгсэл нэвтрүүлэхээр болсон) болон макро эдийн засгийн талаар ярилцлаа.

ТӨВ БАНК ЭНЭ ЖИЛ БОДЛОГЫН ХҮҮГ 3 ДАХЬ УДААГАА БУУРУУЛЖ 8% БОЛГОЛОО. ЭНЭ УДААГИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР ЮУНД ЧИГЛЭЖ БАЙНА ВЭ?

Ковид 19-өөс үүдэлтэй эдийн засгийн хүндрэлээр иргэд болон аж ахуйн нэгжүүд санхүүгийн томоохон сорилттой тулгарч буй энэ үед зээлийн тасалдал үүсгэхгүй байх, санхүүжилтийн өртөг зардлыг бууруулах, мөн зээлийн хүүг бууруулах зэрэг бодлогын зорилтуудтайгаа нийцтэйгээр шийдвэр гаргахыг Төв банк зорьж байна. Бодлогын хүүг бууруулснаар зах зээл дээрх зээлийн хүү, ялангуяа сайн зээлдэгчдийн хувьд санхүүжилтийн нөхцөлийг сайжруулна гэж харж байна. Макро эдийн засгийн орчин муудах үед зээлийн хүү өсөх хандлагатай байдаг ч энэ оны 7-р сарын байдлаар зээлийн дундаж хүү 15.8% буюу 2011 оноос хойших сүүлийн 9 жилийн доод түвшинд хадгалагдаж байна. Энэ

бол цар тахлын сөрөг нөлөөг зөөлрүүлэхээр Төв банкнаас хэрэгжүүлсэн багц арга хэмжээний үр дүн байгаа юм. Өмнөх улиралтай харьцуулахад ханшийн суурь хүчин зүйл болох төлбөрийн тэнцлийн төлөв сайжирч инфляцын дарамт багассан зэрэг нь энэ удаагийн хурлаар мөнгөний бодлогыг зөөлрүүлэх орон зайг олголоо. Үүний зэрэгцээ, Төв банк урт хугацаатай репо хэрэгсэл зах зээлд нэвтрүүлснээр эдийн засгийн хүндрэлтэй үед банкуудын хөрвөх чадвар дээшилж эдийн засагт шинэ зээл нийлүүлэхээс гадна, зээлийн хүү өсөхгүй байхад нөлөөтэй. Өөрөөр хэлбэл, банкууд тодорхой төрлийн сайн зээлээр баталгаажсан үнэт цаас барьцаалан Монголбанкнаас зах зээлийн зарчмаар урт хугацаатай санхүүжилтээр зээл гаргах нэмэлт эх үүсвэртэй болно гэсэн үг.

ИНФЛЯЦ 8-Р САРД 2.1% БОЛЖ БУУРСАН НЬ ХӨГЖИЖ БҮЙ

ОРНЫ ХУВЬД ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХЖИЛ ХУМИГДСАНЫГ ИЛЭРХИЙЛЭХ ХЭТ БАГА ТҮВШИН БОЛЖ БАЙНА. ТӨВ БАНК ҮҮНИЙГ ХЭРХЭН ХАРЖ БАЙНА ВЭ?

Инфляцыг хөөргөдөх эрэлтийн болон нийлүүлэлтийн хүчин зүйлс аль аль нь сул байна. Эрэлт талаас эдийн засгийн идэвхжил сүүлийн 2 улиралд хурдтай суларлаа. Тодруулбал, ДНБ 1-р улиралд -10.7%, 2-р улиралд -9.1% агшсан байна. Хэдийгээр Засгийн газар болон Төв банкнаас иргэдийн амьжиргааг дэмжсэн бодлого хэрэгжүүлж, өрхийн бодит орлого өсөлттэй, хөдөлмөрийн зах зээлийн статистик төдийлөн муудаагүй байгаа ч Ковид 19-тэй холбоотой тодорхой бус байдал зах зээлд оролцогчдын хүлээлтэд сөргөөр нөлөөлсөн хэвээр байна. Харин нийлүүлэлтийн хүчин зүйлсийн хувьд, өнгөрсөн жилүүдэд инфляцыг хөөргөдөж байсан бараа бүтээгдэхүүний үнэд өндөр өсөлт бий болоогүй нь дарамтыг

зөөлрүүлж байна. Тухайлбал мах, хатуу түлшний үнэ харьцангуй тогтвортой, дэлхийн зах зээл дээрх нефтийн үнийг дагаад шатахууны үнэ боломжийн түвшинд хадгалагдаж байна. 8-р сараас хүнсний ногооны үнэ хямдарснаар аль хэдийн нам түвшинд орсон инфляцыг илүү эрчимтэй буурууллаа. Инфляц ийнхүү бага байгаа нь эдийн засагт дэмжлэг шаардлагатайг илэрхийлэхээс гадна мөнгөний бодлогод орон зайг олгож байна. Төв банк өнгөрсөн 3 жилд инфляцын 8%-ийн зорилтоо үр дүнтэй биелүүлсэн тул цаашид зорилтыг бууруулж 6%-ийн түвшний интервалтай онилох бодлогод шилжинэ. Эдийн засгийн идэвхжлийг дагаад инфляц нэмэгдэх ч, цаашид энэ түвшинд тогтворжуулахыг зорьж ажиллана гэсэн үг. Энэ нь Монголбанкны мөнгөний бодлого, үйл ажиллагаа нь бусад өндөр хөгжсөн улс орнуудын Төв банкуудын адил үнийн тогтвортой байдлыг хангах үүднээс инфляцыг онилж тодорхой түвшинд тогтворжуулах зорилт тавин ажилладаг хөгжлийн шинэ шатанд гарсныг илтгэх юм.

ЭДИЙН ЗАСГИЙН ЦААШДЫН БАЙДЛЫГ ХЭРХЭН ДҮГНЭЖ БАЙНА ВЭ? ЭНЭ УДААГИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛ ДЭЭР ЯМАР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНӨВ?

Гадаад орчинд Ковид 19-ийн тархалт үргэлжилж, дэлхийн эдийн засагт сорилт учруулсаар байгаа боловч гол эдийн засгуудад идэвхжил нэмэгдэж байна. Ялангуяа, Хятадын эдийн засаг 2 дугаар улиралд эерэг өсөлттэй, сүүлийн саруудад үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарын

үйл ажиллагаа тэлэлттэй байгаа нь экспортын гол түүхий эдийн эрэлт болон үнэд эерэгээр нөлөөллөө. Олон улсын санхүүгийн байгууллагууд ч оны эхний хагаст хийж байсан төсөөлөл тооцооллоо эргэн харж, зарим нь сайжруулж дэлхийн эдийн засгийн төлөвийг өөдрөг тал руу нь засварлаж байна. Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөг бууруулах, зах зээлийн итгэлийг сэргээж, нийт эрэлтийг тэтгэн эдийн засгийн огцом уналтаас зайлсхийх зорилгоор хөгжингүй болон хөгжиж байгаа орнуудад төсвийн тэлэх бодлогыг түлхүү ашиглаж байгаа нь нэг талдаа өрийг нэмэгдүүлж байгаа ч эерэг үр дүнгээ зохих хэмжээгээр үзүүлж эхлээд байна. Түүнчлэн гол Төв банкуудын шийдвэрийн нөлөөгөөр гадаад зах зээл дээр ам.долларын санхүүжилтийн өртөг буурч байна.

Дотоодын эдийн засгийн нөхцөл байдлыг авч үзвэл үйлдвэрлэл талаас өнгөрсөн 2 улиралд 30% орчим унаад байсан уул уурхайн салбарт сэргэлт ажиглагдахын зэрэгцээ агшилттай байсан үйлчилгээний салбарууд дээр хөл хорио цуцлагдаж байгаа нь бизнесийн идэвхжлийг нэмэгдүүлэх эерэг нөлөөтэй. Мөн эрэлт талаас цэвэр экспорт дээр гол эерэг өөрчлөлт бий боллоо. Хэдийгээр төлбөрийн тэнцэл сайжирсан дүр зурагтай байгаа ч санхүүгийн зах зээл дээр идэвхжил сул, бодит секторын гүйцэтгэл тааруу хэвээр байгаа тул Мөнгөний бодлогын хорооны гишүүд эдийн засагт дэмжлэг шаардлагатай гэдэг дээр бүгд санал нэгдсэн. Анх бодлогын хүүг 0.5%-аар бууруулах саналыг

хэлэлцсэн ч, бодлогын орон зай байгааг харгалзан хүүг 1%-иар буулгаж, зоримог гэж дүгнэж болох шийдвэрийг гаргалаа. Бизнесийн байгууллагуудын энэ өвлийн бэлтгэл хангалт, дээр нь ирэх 2021 оны бизнесээ төлөвлөж буй үед хүүг бууруулах шийдвэр нь зах зээл дээр чухал дохио болох юм. Бодлогын орон зай талаас шийдвэр гаргахад зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай нэг асуудал нь төгрөгийн ханшийн хөдөлгөөн байсан. Өнөөдөр бидний хувьд суурь хүү болгон ашиглаж байгаа Төв банкны үнэт цаасны хүү буюу бодлогын хүү нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн өгөөжийг илэрхийлж байгаа учир төгрөгийн ханшид ирэх дарамтыг нарийн тооцоолох, эрсдэлийг үнэлэх явдал чухал байдаг.

ТЭГВЭЛ БОДЛОГЫН ХҮҮГ БУУРУУЛСНААР ТӨГРӨГИЙН ХАНШ ДЭЭР ДАРАМТ ҮҮСЭХ ВИЙ ГЭСЭН БОЛГООМЖЛОЛ БИЙ. ҮҮНИЙГ ХЭРХЭН ТАЙЛБАРЛАХ ВЭ?

Хүүг бууруулснаар ханшид ирэх дарамт нь зээлийн суваг хэр хүчтэй ажиллаж улмаар импортыг нэмэгдүүлж төлбөрийн тэнцэлд хэр зэрэг дарамт үүсэх эсэхээс, мөн валютын орох урсгал болон гадаад валютын албан нөөцөөс ихээхэн хамаарна. Зээлийн хувьд, эдийн засгийг тэтгэх энэхүү гол санхүүгийн эх үүсвэрийг тогтвортой байлгах, санхүүгийн зуучлалын тасалдал үүсгэхгүй байх нь чухал. Сүүлийн саруудад зээл аль хэдийн 5% орчим агшилттай яваа тул төлбөрийн тэнцэл дээр том дарамт үүсгэхгүй болов уу. Валютын орох, гарах урсгалын хувьд, хэд хэдэн эерэг өөрчлөлтийг нэрлэж



болно. Нэгт, гадаад худалдааны тэнцэл дээр эерэг өөрчлөлт ажиглагдаж байна. Алтны үнэ түүхэн дээд \$2000 орчимд, зэсийн үнэ \$6000-аас дээш боломжийн түвшинд, нүүрсний экспорт сэргэж, хилээр 2000 орчим тээврийн хэрэгсэл нэвтэрч буй байдал, түүнчлэн импортууд болон зарим үйлчилгээний зардал хумигдан, ялангуяа нефтийн үнэ дэлхийн зах зээл дээр \$40 орчимд буюу харьцангуй хямд байгаа зэрэг нь урсгал тэнцлийг сайжруулж валютын урсгалд эерэгээр нөлөөлж байна. Хоёрт, олон улсын байгууллагууд, хөгжлийн түнш орнуудтай үргэлжлүүлэн хамтран ажиллаж, санхүүжилтүүд хэвийн орж ирж байгаагийн зэрэгцээ “Оюу толгой” төслийн далд уурхайн хөрөнгө оруулалт хэвийн үргэлжлэх, хуваарийн

дагуу орж ирэхээр байна гэж харж байна. Валютын нөөцийн хувьд, импортын 7-8 сарын хэрэгцээг хангахад хүрэлцээтэй хэвээр, ханшийн огцом савлагааг үүсгэхгүй байхад чиглэсэн арга хэмжээг Төв банк хэрэгжүүлж ирлээ. Ковид-19 олон улсын эдийн засагт түүхэнд байгаагүй огцом уналтыг бий болгон зарим түүхий эд экспортлогч орны мөнгөн тэмдэгт 10-30% хүртэл суларсан. Харин Монгол төгрөг ам.долларын эсрэг оны эхнээс 4.4% орчим суларсан нь гол экспортын орлого 40-50% хүртэл тасарсан хүнд үед харьцангуй сайн үзүүлэлт гэж харж байна. Гадаад сөрөг шокыг дан ганц валютын нөөц дээр авах боломжгүй бөгөөд тодорхой хэмжээний ханшийн тохиргоо нь дунд хугацаанд эдийн засгийн тогтворгүй байдлаас сэргийлэх суурь болох учиртай.

Ерөнхийд нь дүгнэж хэлбэл, Төв банкны хувьд улсын валютын нөөц хангалттай хэмжээнд хуримтлагдан өсч байна. Өмнөх улирлын Мөнгөний бодлогын хорооны хурлаас хойш төлбөрийн тэнцэл сайжирч, тухайлбал худалдааны тэнцэл 8-р сард нэг тэрбум ам.долларын ашигтай гарч оны эхний хагаст үүсээд байсан алдагдал нөхөгдсөн. Санхүүгийн тэнцэл талаас бол олон улсын байгууллага болон хөгжлийн түнш орнуудаас энэ ондоо багтан 700 сая ам. долларын зээл тусламж үзүүлэх гэрээ хэлцэл хийгдэж байгаа зэрэг эдийн засагт бий болсон өөрчлөлт, шинэ мэдээлэлд үндэслэн төгрөгийн ханш огцом савлагаа үүсэх эрсдэл буурсан. Ингээд эдгээрээс үзэхэд ханш

өмнөх онуудынхаа хандлагаар тогтвортой байх боломжтой гэж тооцоолоод байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН ТААРУУ, ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ МУУДАЖ БУЙ ЭНЭ ҮЕД БОДЛОГЫН ХҮҮГ БУУРУУЛЖ, БАНКУУД НЭМЭЛТ ЭХ ҮҮСВЭРТЭЙ БОЛЛОО Ч ЗЭЭЛ ОЛГОЖ ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ ЭСЭХЭД ЭРГЭЛЗЭЖ Л БАЙНА.

Юуны өмнө, дотоод эдийн засгийн орчны талаар дэлгэрэнгүй тайлбарлах хэрэгтэй болов уу. ДНБ оны эхний хагас жилд 9.7% агшсан боловч үүний гол шалтгаан болсон уул уурхайн салбар (ДНБ-ийн агшилтын 6.2 нэгж хувийг дангаараа тайлбарласан), ялангуяа нүүрсний экспорт, үйлдвэрлэл 8-р сараас эхлэн сэргэсэн нь том эерэг өөрчлөлт юм. Энэ нөлөө эхний ээлжинд худалдаа, тээвэр болон боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудад мэдрэгдэнэ. Түүнчлэн, үйлчилгээний салбаруудын бизнесийн үйл ажиллагааг хязгаарлаж байсан хөл хорио 3-р улирлаас суларч, идэвхжил нэмэгдэх төлөвтэй байна. Харин эрэлт талаас экспортын биет хэмжээ нэмэгдэн гадаад худалдаан дээр эерэг өөрчлөлт бий болсны зэрэгцээ төсөв, мөнгөний бодлогоор хэрэглээ, хөрөнгө оруулалтыг дэмжиж байгаа нь өсөлтийг дэмжинэ. Хоёрт, банкуудын хувьд сайн зээлдэгч нартаа санхүүгийн зуучлал үзүүлснээр бизнесийн үйл ажиллагаа, ажлын байр, хэрэглээг тэтгэх нь макро орчин хурдан тогтворжиход чухал нөлөөтэй. Энэ нь мэдээж эргээд банкны салбарын үйл ажиллагаа, санхүүгийн

системийн тогтвортой байдалд ч чухал. Төв банк санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэх, сорилтын энэ үед макро эдийн засгийг тогтвортой байлгахын тулд бодлогын бүх хэрэгслээ ашиглах болно. Төв банкинд бодлогын хэрэгслийн хувьд ч, хүний нөөц, чадавхын хувьд ч хангалттай боломж бий, тэр хэмжээнд бэлтгэгдсэн институци болж төлөвшиж хөгжсөн.

КОВИД 19-ИЙН ҮЕД УЛС ОРНУУДАД ТУЛГАРЧ БУЙ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ГОЛ СОРИЛТЫН ТАЛААР БОЛОН ЦААШДЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛД АНХААРАХ ЗҮЙЛСИЙН ТАЛААР ТА ТОДОРХОЙ ТАЙЛБАРЛАЖ ӨГӨӨЧ.

Олон улсад эдийн засгийн үйл ажиллагааг эрэлт, нийлүүлэлт талаас нь зэрэг хумисан цар тахал хэзээ намжиж бүрэн хяналтад орох нь тодорхой бус байгаа нь гол сорилт юм. Чанга хөл хорионы нөлөөгөөр дэлхийн гол эдийн засгууд 2 дугаар улиралд хүчтэй агшсан ч, эдийн засгийн үзүүлэлтүүд сүүлийн 2-3 сард идэвхжиж эхэллээ. Гэхдээ вакцингүй үед вирусийн эрсдэл хэвээр, зарим орнуудад цар тахлын 2 дахь давалгаа үүсч болзошгүй байна.

Монголбанкны хувьд, хүндрэлийн үед цалин орлого эсвэл борлуулалт нь хумигдсан иргэд, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн хөрвөх чадварын түр зуурын эрсдэлийг цааш гүнзгийрэхээс сэргийлэх, хүндрэлийг зөөллөхөд зорьж,

ажиллаж ирсэн. Өмнөх гаргасан шийдвэрүүд үр дүнгээ өгч байгааг та харж байгаа байх. Цаашид гаргах бодлого, шийдвэр маань мөн адил байх болно. Зах зээл дээрх санхүүжилтийн нөхцөлийг зөөлрүүлэх, зээлээр дамжуулж хэрэгжих мөнгөний бодлого нь уналтын шокиг зөөлрүүлж, эдийн засгийг дэмжихэд үр дүнтэй. Харин нэгэнт ядуу эмзэг бүлэг болон үйл ажиллагаа нь бүрэн зогсчихсон аж ахуйн нэгжүүдэд зээл төдийлөн тус болохгүй учраас төсвийн зарцуулалт чухал юм. Иймд хямрал удаан үргэлжилсэн тохиолдолд зарцуулах санхүүгийн нөөцтэй байх, Ковид 19-ийн дараа эдийн засгийг сэргээх сангийн бодлогын орон зайг хадгалах нь чухал.

Мөн бид энэ хүндрэлийг манай эдийн засгийн буруу бүтцийг сууриар нь засах боломж гэж харж байна. Төр нь ч, хувийн хэвшил нь ч тэр санхүүгийн шийдвэр гаргахдаа яг одоогийн ажлын байр, өсөлтийн статистик гэхээсээ илүүтэй ирээдүйд аль эдийн засгийн салбар, ямар бизнес моделийг дэмжиж хөгжүүлэх вэ гэдгийг нухацтай бодох шаардлагатай. Түүнчлэн улс орнуудад цар тахлын үед технологид суурилсан цахимаар ажиллах бизнес загвар түлхүү хөгжиж байна. Түүнчлэн, өмнө нь үйлдвэрлэл, үйлчилгээ үндэстэн дамнасан байдлаар хоорондоо маш уялдаа хамааралтай нийлүүлэлтийн буюу өртгийн сүлжээнд тулгуурлаж ирсэн бол харин одоо хорио цээрийн

дэглэмээс шалтгаалан өөрчлөгдөж, илүү бие даасан бүтэц боломжийг судлах боллоо. Дэлхий нийтээрээ шинэ нөхцөл байдалд дасан зохицохоор тэмүүлж, эрэл хайгуул хийж байгаа үед бид хоцорч болохгүй.


Ярилцсанд баярлалаа!



Бодлогын хүүний өөрчлөлт

Бодлогын хүү 8 хувьд хүрлээ

Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 9 дугаар сарын 14-ний өдрийн хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 8 хувьд хүргэх, урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх шийдвэр гаргалаа.



Хэмжих нэгж: хувиар

Энэхүү шийдвэр нь эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан үзээд банкны салбараас эдийн засгийн бодит секторт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэв.



Тухайн шийдвэр, арга хэмжээ нь инфляцын зорилтыг хангаж, эдийн засгийн уналтыг сааруулан, улмаар сэргэлтийг дэмжинэ. Ингэснээр бодлогын хүү он гарснаар 3 нэгж хувиар буурч, сүүлийн 10 жилийн хамгийн доод хэмжээндээ хүрэв.





МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС... (2020.09.14)

Мөнгөний бодлогын хорооны ээлжит хуралдаан 2020.09.14-ний өдөр хуралдаж, бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах, банк хоорондын захад урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгсэл нэвтрүүлэх шийдвэр гаргасантай холбогдуулж мэдээлэл хийсэн хэвлэлийн бага хурлын тэмдэглэлийг танилцуулж байна.

Блүүмбэрг ТВ: Мөнгөний бодлогын газраас бодлогын саналаа оруулахдаа анхнаасаа 1 нэгж хувиар бууруулахаар байсан уу?

Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г.ЭНХТАЙВАН:

Монголбанкны мөнгөний бодлогын газраас бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулж, 8.5 хувьд хүргэх санал оруулж ирсэн. Мөнгөний бодлогын хорооны гишүүдийн 100%-ийн саналаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулахаар шийдвэрлээд байна.

Блүүмбэрг ТВ: Урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгслийн талаар дэлгэрэнгүй тайлбарлана уу?

Одоогийн мөнгөний бодлогын хэрэгслээр хоёр долоо хоног хүртэлх хугацаатай репо санхүүжилт олгож байгаа. Үүнийг хоёр жил хүртэлх хугацаатай болгож байна. Цар тахлын үед дэлхийн улс орнуудын Төв банкууд зах зээл дээр урт хугацаатай санхүүжилтийн хэрэгслүүд гаргаж, эдийн засгийг дэмжих бодлого хэрэгжүүлж байгаа. Монголбанкны хувьд ч бас үүнийг хугацаа алдалгүйгээр зах зээл дээр нэвтрүүлэх нь зүйтэй юм гэж үзсэн. Репо санхүүжилтийн хүрээнд арилжааны банкуудад байгаа сайн зээлийг үнэт цаасжуулна. Уг үнэт цаасжуулсан багцыг Монголбанк худалдан авах бөгөөд ингэхдээ бодлогын хүү дээр нэмэх нь 0.5 нэгж хувийн хүүтэйгээр банкуудад санхүүжилт олгох юм. Тэгэхээр арилжааны банк эрсдэл, ашгийн маржинаа

нэмээд, зээл гаргахдаа хүүгийн хэмжээг сарын 1 хувиас хэтрүүлэхгүйгээр олгох боломжтой болно.

Блүүмбэрг ТВ: Мөнгөний бодлогын хорооны гишүүнээс асууя. Бодлогын санал нь 0.5 нэгж хувиар бууруулахаар орж ирсэн юм байна. Хорооны гишүүд хуралдааны явцад ямар үндэслэл, шаардлагаар бодлогын хүүг илүү өндөр хувь буюу 1 нэгж хувиар бууруулах нь зүйтэй гэж үзсэн юм бол?

Мөнгөний бодлогын хорооны гишүүн Ц.МӨНХБАЯР:

Мөнгөний бодлогын санал нь анхнаасаа 0.5 нэгж хувиар бууруулахаар орж ирсэн. Хуралдааны үеэр гишүүдийн гаргасан 1 хувиар бууруулах санал хоёр зүйлд үндэслэсэн. Нэгдүгээрт, инфляц энэ оныг дуустал тогтвортой, нам түвшинд хадгалагдахаар байна. Ирэх онд эдийн засгийн өсөлт сэргэж, инфляц алгуур нэмэгдэх хэдий ч, 6%-ийн зорилтот түвшинд тогтворжихоор байна. Хоёрдугаарт, төлбөрийн тэнцэл нэмж муудахгүй байх төсөөлөлтэй холбогдож байгаа юм. Бодлогын хүүг өөрчлөхөд хамгийн чухалд авч үзэх ёстой үзүүлэлт нь гадаад сектор байдаг. Өөрөөр хэлбэл, төлбөрийн тэнцлийн дарамт гэсэн үг. Энэ он болон ирэх оны төлбөрийн тэнцлийн төлөвийг харахад гаднаас орж ирэх хөрөнгө оруулалт болон гадаадын шууд хөрөнгө оруулалт, багцын хөрөнгө оруулалтын урсгал нь бидний өмнөх хурлын үеэр төсөөлж байснаас сайжирсан. Мөн

гадаад валютын нөөц нэмэгдэх төсөөлөлтэй байна. Гуравдугаарт, экспортын хэмжээ импортоосоо илүү хурдацтай өсч байна. Нүүрс, зэсийн үнэ ирэх онд бага зэрэг буурахаар байгаа ч, гадаад төлбөрийн тэнцлийн тогтвортой байдлыг хангахуйц түвшинд хадгалагдахаар байна. Эдгээр үндэслэлээр бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах нь зөв гэж гишүүд үзсэн.

Ийгл ТВ: Зах зээл дээр урт хугацаат репо санхүүжилтийг нэвтрүүлснээр зээлийн хүүг нэг оронтой тоонд оруулна гэж байна. Энэ талаар дэлгэрэнгүй тайлбарлана уу?

Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.ЭНХЖИН:

Ковид-19 цар тахлын улмаас эдийн засагт үүсч байгаа хүндрэлийг шийдвэрлэх, эдийн засгийг дэмжих, банкны зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Төв банкнаас олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа. Өмнөх хурлуудаар бодлогын хүүг хоёр нэгж хувиар бууруулах, төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг мөн хоёр нэгж хувиар бууруулах зэрэг арга хэмжээг авсан. Гэхдээ эдийн засгийн агшилт бидний тооцоолсноос илүү хүчтэй байж, банкны зээлийн нийлүүлэлт буурсаар байна. Тэгэхээр Монголбанкны зүгээс эдийн засгийг дэмжих, банкны зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний бодлогын хороонд санал оруулж, дэмжигдсэн. Монголбанкнаас өмнө нь авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн хүрээнд Төв банкнаас арилжааны банкинд олгох санхүүжилтийг хөнгөвчлөх зорилгоор барьцаа хөрөнгийн төрлийг нэмэгдүүлж, бодлогын хүүг бууруулсан хэдий ч, банкны системд хөрвөх чадвартай актив хөрөнгийн хэмжээ хязгаарлагдмал байна. Төв банкны үнэт цаасны нийт үлдэгдлийн 72 хувь нь хоёр банкинд 95 хувь нь дөрвөн банкинд төвлөрсөн байгаа. Засгийн газрын үнэт цаас 2017 оноос хойш гараагүй учраас мөн л хязгаарлагдмал хэмжээтэй байна. Үүнээс шалтгаалаад банкууд Төв банкнаас эдгээр активыг барьцаалж санхүүжилт авахад хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн. Нөгөө талаас уул уурхайн бус экспортын салбарыг дэмжих, ЖДҮ эрхлэгчдийг дэмжих зорилгоор Төв банкнаас энэ чиглэлийн арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзсэн. Дэд Ерөнхийлөгчийн хэлсэнчлэн, Монголбанкнаас арилжааны банкуудын уул уурхайн бус экспортын салбар болон ЖДҮ эрхлэгчдэд олгосон хэвийн зээлийг багцлан үнэт цаасжуулах замаар хоёр хүртэлх жилийн хугацаатай санхүүжилт олгохоор

болсон. Энэ нь бодлогын хүүн дээр нэмэх нь 0.5 нэгж хувиар олгогдоно. Үүн дээр банкууд эрсдэлийн үнэ өөрсдийн ашгаа нэмээд, бидний тооцоолж байгаагаар 3 нэгж хувийг нэмснээр уул уурхайн бус экспортын салбарт 11.5 хувийн хүүтэй зээл олгох боломж бүрдэнэ гэж үзсэн. Өнөөдөр Мөнгөний бодлогын хороогоор энэ санал дэмжигдсэн учраас дөрөвдүгээр улиралд багтаад, Монголбанкнаас санхүүжилт олгож эхэлнэ.

Ikonn.mn: ФАТФ-аас газар дээрх хяналтын ажлын хэсэг энэ сард багтаж ирнэ гэж байна. Энэ асуудал ямар шатандаа явж байна вэ?

Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г.ЭНХТАЙВАН:

Монголбанк, Засгийн газар хамтран ФАТФ-ын стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтаас гарахаар ажиллаж байна. 10 дугаар сарын эхээр ФАТФ-аас газар дээрх хяналт, шалгалтын баг ирж ажиллахаар төлөвлөж байна. Гэхдээ цар тахалтай холбоотой хорио цээрийн дэглэм дэлхийн улс орнуудад харилцан адилгүй үйлчилж байгаа учраас бид газар дээрх хяналтын багийг хэрхэн авчрах, мөн тухайн багийн гишүүдийн байгаа улс орнууд руу нисэх тусгай үүргийн онгоцуудыг ямар хуваариар хэрхэн нисгэх вэ зэрэг асуудлыг судалж байна. Ер нь бол 10 дугаар сарын эхний 7 хоногт багтаад газар дээрх хяналтын багийг авчирна гэсэн хүлээлттэй байна.

Өнөөдөр сонин: Энэ удаагийн мөнгөний бодлогын хорооны хурлаар эдийн засгийн төсөөллүүдийг шинэчилсэн байх. Эдийн засгийн төсөөллүүдэд ямар өөрчлөлт гарсан бэ?

Мөнгөний бодлогын газрын захирал Б.БАЯРДАВАА:

Зургаадугаар сарын мөнгөний бодлогын хорооны хурлаар 2020 оны эдийн засгийн өсөлтийг -0.9 хувь гэж тооцоолж байсан. Наймдугаар сард болсон Мөнгөний бодлогын хорооны ээлжит бус хурлаар бид -1.5 хувь байх нь гэж тооцсон. Энэ удаад хоёрдугаар улирлын эдийн засгийн өсөлтийн бодит гүйцэтгэл дээр үндэслэн, гадаад эдийн засгийн орчны өөрчлөлт зэргийг тусгаж үзсэнээр 2020 оны эдийн засгийн өсөлтийг бид -2.6 хувь байхаар төсөөлж байна. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл улирлаас улиралд бидний хүлээлтээс давж, муу үзүүлэлттэй гарч байгаа нь бодлогын хүүг бууруулах бас нэгэн шалтгаан болж байгаа. Мөн эдийн засаг

руу гарч байгаа санхүүжилтийн хувьд бакнаас олгож байгаа санхүүжилтийн хэмжээ буурч байна. Энэ нөхцөл байдал цаашид удаан үргэлжилбэл, зээлийн тасалдал үүсч болзошгүй. Төсөв болон санхүүгийн зохицуулалтын хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд энэ оны эцэс хүртэл хэрэгжинэ. Эдгээр арга хэмжээ нь 2021 оны эхнээс эхлээд хэвийн түвшиндээ хүрэх үед эдийн засаг дахь санхүүжилтийн эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэж болзошгүй байна. Тэгэхээр нөхцөл байдалдаа тааруулан, урьдчилан сэргийлэх зорилгоор өнөөдрөөс бодлогын арга хэмжээг авч байгаа юм. Өмнө Мөнгөний бодлогын хорооны гишүүний хэлсэнчлэн инфляц энэ ондоо бага түвшинд хадгалагдана. Ирэх онд инфляц Монголбанкны зорилтот түвшнээс давахгүй. Эдийн засгийн өсөлт сэргэх боловч гадаад орчноос хамаарал өндөртэй байна. Санхүүгийн зуучлал доголдож, зээлийн нийлүүлэлт хумигдаж магадгүй байгаа учраас яаралтай арга хэмжээ авч байгаагаараа онцлогтой. Тэгэхээр хуучин байсан санхүүжилтийн цонхыг өөрчилж, илүү урт хугацаатай, илүү олон төрлийн барьцаа хөрөнгөөр дамжуулж олгох бололцоог бүрдүүлж байна. Мөн санхүүжилтийн хүү нь бодлогын хүүн дээр суурилан бага байх бололцоог бүрдүүлж байгаа нь эдийн засагт буй санхүүжилтийг нэмэгдүүлэх, зээлийн хүүг нэмэгдүүлэхгүй байх, болж өгвөл бууруулах зорилгод дэмжлэг болно гэж үзсэн. Энэ бүх арга хэмжээ нь бодлогын хүүний бууралттай нийлснээр одоо явагдаж байгаа эдийн засгийн уналтыг сааруулахаас гадна ирээдүйн эдийн засгийн сэргэлтэд дэмжлэг болно гэж үзсэн.

NTV ТВ: Монголбанкны интервенц он гарснаас хойш цэвэр дүнгээр хэдэн ам.долларт хүрээд байна вэ. Ханшийн тогтвортой байдлын талаар мэдээлэл өгнө үү?

НУСЗЗГ-ын захирал А.ЭНХЖИН:

Монголбанк он гарснаас хойш дотоодын валютын захад 2.3 тэрбум ам.доллар нийлүүлж, 1.5 тэрбум ам.доллар худалдаж авснаар цэвэр дүнгээр 800 орчим сая ам.долларыг нийлүүлээд байна. Хэдийгээр интервенц цэвэр дүнгээрээ өссөн ч Монголбанкны зүгээс ханш энэ оныг дуустал тогтвортой байна гэж харж байгаа. Долоодугаар сарын төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг харвал алдагдал нь өмнөх сараас 300 гаруй сая ам.доллараар буурсан. Тэгэхээр Монгол Улсад орж ирэх валютын урсгал харьцангуй нэмэгдэх болов уу гэсэн хүлээлт байна. Нөгөө талаас дотоодын валютын захад

мөн тогтвортой байдал ажиглагдаж эхэлсэн. Сүүлийн өдрүүдэд валютын дуудлага худалдаагаар банкуудаас ирүүлэх валют худалдан авах саналын дүн харьцангуй буурсан.

Gogo.mn: Ипотекийн зээлийн хүүг 6 хувь болгож бууруулах асуудал яригдаж эхэлсэн. Энэ ажил хэзээнээс ажил хэрэг болох вэ?

Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван:

Монголбанкнаас Засгийн газартай хамтран ипотекийн зээлийн хүүг бууруулах асуудлыг судалж байна. Өнгөрсөн долоо хоногт Засгийн газрын хуралдаанаар ипотекийн зээлийн хүүг бууруулах ажлыг судлах ажлын хэсгийг байгуулсан. Түүнээс биш хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарч байгаа шиг 6 хувь болгох эцсийн шийдвэр гараагүй байгаа. Монголбанкнаас энэ оны тавдугаар сараас эхлэн арилжааны банкуудаар дамжуулан ипотекийн зээлийн санхүүжилтийг олгож байна. Одоогийн байдлаар Монголбанк тавдугаар сараас хойш 146.3 тэрбум төгрөгийг арилжааны банкуудад олгож, 2100 орчим иргэнд ипотекийн зээл олгоод байна. Хэрвээ ипотекийн зээлийн хүүг бууруулах асуудал шийдэгдвэл энэ нь 2021 оны нэгдүгээр сараас хэрэгжиж эхэлнэ.

Ikona.mn: УИХ-аар зээлийн хүүг бууруулах стратеги батлагдсан. Уг стратегийн дагуу Монголбанкнаас тодорхой ямар ажил хийж, хэрэгжүүлж эхэлсэн бэ?

Монголбанкны Ерөнхий эдийн засагч Д.ГАН-ОЧИР:

УИХ-аар "Зээлийн хүүг бууруулах стратеги" батлагдсан. Энэ дагуу Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл уг асуудлыг хэлэлцэж, стратегийг хэрэгжүүлэх талаар чиглэл өгсөн. Үүний дагуу дундын ажлын хэсэг байгуулан, эхний ээлжинд стратегийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлахаар болсон. Улмаар төлөвлөгөөнийхөө тогтмол хэрэгжилтийг байгууллага тус бүр дээр хангаад явъя гэдэг чиглэлтэй байна. Одоо холбогдох байгууллага бүр тус тусдаа ажлын төлөвлөгөө боловсруулж байна. Үүний дараа дундын ажлын хэсэг дээр төлөвлөгөөг нэгтгэж, хэрэгжүүлэх юм. Үүнийг хүлээхгүйгээр Монголбанкны зүгээс холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. УИХ-аар батлагдсан стратегийг харвал санхүүгийн зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн гаргах, зээлийн тасалдал, түүний үр дагаврыг бууруулах зорилгоор уул уурхайн бус экспорт

болон ЖДҮ-ийг дэмжих зорилгоор эх үүсвэр гаргах гэдэг заалт орсон. Энэ нь Мөнгөний бодлогын хорооны хурлаар албажлаа. Удахгүй энэ оны дөрөвдүгээр улиралд энэ зорилгоор олгох санхүүжилтийн хэмжээ, бусад нөхцөл зэрэг нь тодорхой болно. Нөгөө талаас стратегийн гол онцлогийг та бүхэн харж байгаа байх. Сүүлийн жилүүдэд бодит практикаар шалгагдсаны дагуу зээлийн хүүг бууруулахад эрх зүйн тогтолцооны шинэчлэл зайлшгүй хэрэгтэй болсон гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрч, стратегидаа тусгасан. Тухайлбал, чанаргүй зээлийг хэрхэн шуурхай шийдвэрлэхтэй холбоотой багц хууль УИХ-д өргөн баригдаж, батлагдах ёстой. Банкны хяналт, шалгалтыг олон улсын стандартад нийцүүлэхтэй холбоотойгоор Банкны хуулинд өөрчлөлт орох ёстой. Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах, мөнгө хүүлэлтийн асуудлыг зохицуулахтай холбоотой багц хуулиуд гарах ёстой. Энэ бүх хуулиуд тус бүр дээр ажлын хэсгүүд гараад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийг боловсруулсан. Одоо эдгээр төслүүд дээрээ дахин ажиллаж, энэ намрын чуулганаар өргөн барихаар ажиллаж байна. Тэгэхээр ажил эхэлчихсэн, эхнээсээ хэрэгжилт хангагдаж байна.

Блүүмбэрг ТВ: Монголбанк ипотекийн зээл буюу төсвийн шинжтэй арга хэмжээнээс гарсан. Гэтэл ОУВС-ийн хөтөлбөр дууссаны дараа эргээд харин ч бүр Монголбанкны ихээхэн оролцоотойгоор энэ хөтөлбөрийг үргэлжлүүлэхээр болж байх шиг байна. Үүний учир шалтгаан юу вэ?

Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г.ЭНХТАЙВАН:

Өмнөх ипотекийн зээлийн санхүүжилтийн схемээс Монголбанк 2020 оны нэгдүгээр сарын 1-нээс гарахаар ОУВС-тай тохиролцсоны дагуу гарсан. Дэлхий нийтийг хамарсан цар тахал, түүний нийгэм, эдийн засагт учруулах хохирлыг бууруулах хууль батлагдсан. Энэхүү хуулийн үйлчлэлийн хүрээнд Төв банкнаас арилжааны банкуудад энэ оны тавдугаар сараас эхлэн ипотекийн зээлийн санхүүжилтийг олгож байгаа. Цар тахлын хуулийн үйлчлэлийн дагуу энэ хөтөлбөр 2020 оны арванхоёрдугаар сарын 31-ний өдрийг хүртэл үргэлжилнэ. Хуулийн үйлчлэл цаашид сунгагдах эсэхийг мэдэхгүй байна. Хэрвээ хуулийн үйлчлэл сунгагдвал ипотекийн санхүүжилт ч мөн цаашид олгогдоод явна. Ипотекийн зээлийн хүүг бууруулах талаар ажлын хэсэг гарч, судалгаа эхэлсэн. Монголбанк, Сангийн яам, БХБЯ, ХЗДХЯ, Улаанбаатар хотын Засаг даргын Тамгын

газраас холбогдох хүмүүс ажлын хэсэгт орон судалгааны түвшинд ажил үргэлжилж байна. 2021 оноос эхлэн орон сууцны санхүүжилтийн схемийг урт хугацаандаа ямар схемээр явуулбал илүү үр дүнтэй вэ, олон улсын жишиг нь юу вэ гэдгийг ажлын хэсгээс судалж байна. Төв банк ОУВС болон бусад олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу төсвийн шинжтэй үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй гэж амлалт өгсөн. Гэвч цар тахлын үед нийгэм, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх, иргэдийг хямд эх үүсвэртэй орон сууцанд хамруулах зорилтын хүрээнд Монголбанк уг хөтөлбөрт хамтран ажиллаж байна.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

2020 ОНЫ 8 ДУГААР САР ТУХАЙН САРД ОЛГОСОН ЗЭЭЛ

*Ипотекийн 8 хувийн хүүтэй олгосон зээл, “Алт” хөтөлбөрийн зээл, Хөгжлийн банкны санхүүжилтээр олгосон зээлүүдийн дүнг оруулж тооцоогүй болно.

**Овердрафт кредит картын зээл тухайн олгогдсон сардаа хүү бодогддоггүй болно.

2020 ОНЫ 8 ДУГААР САР

ЗЭЭЛИЙН
ЖИГНЭСЭН
ДУНДАЖ
ХҮҮ

16.5%

17.0% ИРГЭД

Үүнээс: Цалингийн зээл 17.7%
Тэтгэврийн зээл 16.6%
Малчны зээл 21.4%

(867.5 тэрбум ₮)

16.1% ХУВИЙН
БАЙГУУЛЛАГА

Үүнээс: Шугамын зээл 15.6%
Овердрафт зээл 21.2%

(512.6 тэрбум ₮)

4.0% УЛСЫН
БАЙГУУЛЛАГА


Үүнээс: Шугамын зээл 19.2%
Овердрафт зээл 0.9%

(22.7 тэрбум ₮)

17.7% БУСАД
САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГА

Үүнээс: Шугамын зээл 17.7%
Овердрафт зээл 28.6%

(28.8 тэрбум ₮)






СТАТИСТИК МЭДЭЭЭЛЛИЙН ТОЙМ


2020 оны 9 дүгээр сарын статистик мэдээллийн тойм

Мөнгөний үзүүлэлт

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (эх үүсвэр талаас)




Зураг 1.2 Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (байршуулалт талаас)



- Мөнгөний нийлүүлэлт (М2 мөнгө) өмнөх оны мөн үеэс **5.0** хувиар өсч **21.5** их наяд төгрөгт хүрлээ. М2 мөнгөний жилийн өсөлтийн **8.4** нэгж хувийг гадаад валютын хадгаламж, **2.4** нэгж хувийг төгрөгийн хадгаламж, **-2.7** нэгж хувийг төгрөгийн харилцах, **-3.2** нэгж хувийг гадаад валютын харилцах тус тус бүрдүүлж байна.
- М2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл, Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн **18.4** их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн **3.1** их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна.

Зээл

Зураг 2.1. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт, сектороор




Зураг 2.2. Зээл, зээлийн чанар



- Нийт зээл **17.2** их наяд төгрөг (төгрөгийн зээл **15.7** их наяд, гадаад валютын зээл **1.5** их наяд төгрөг)
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас **0.3%**-иар
- Хэвийн зээл өмнөх сараас **0.2%**-иар
- Чанаргүй зээл өмнөх сараас **1.2%**-иар
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас **0.03%**-иар өссөн байна.

Төлбөрийн тэнцлийн статистик, 2020 оны эхний 8 сар /урьдчилсан/



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

ТИЙН ЯЛСАН СУВАРГА

ХІХ-ХХ ЗУУН

Жин: 738 гр

Өндөр: 22 см

Суурь: 14х14см

АЛТ ШАРМАЛ МӨНГӨ, ХӨӨМӨЛ

1985 оны 12 дугаар сард Өмнөговь аймгийн 10 жилийн сургуулийн хичээлийн эрхлэгч, иргэн

С.Жаргалаас Эрдэнэсийн санд худалдан авчээ.

Тийн ялсан суваргыг мөн насан хутгийн, нас уртасгасны суварга гэхчлэн нэрлэх бөгөөд бурхан багш наян насан дээрээ шавь нарынхаа хүсэлтээр насаа гурван сараар уртасгасан үйлийг мөнхжүүлж, эртний Энэтхэгийн Вайсали хотод анх бүтээжээ. Тийн ялсан суварга нь бурхан багшийн номлол сургааль үхлийг ялан дийлснийг бэлгэдэх бөгөөд ялгагдах онцлог нь чимэггүй дугуйрсан шаттай болно.



ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ШААРДЛАГАТАЙ САЛБАРТ, ЗӨВ БОДЛОГООР ТАТАХ НЬ ЧУХАЛ

Б.Анхцэцэг¹ Б.Гэрэлмаа²

Эдийн засгийн тогтвортой өсөлтийг тодорхойлогч дотоод хуримтлал нь хөгжиж буй орнуудад хангалттай байдаггүйн улмаас гадаад санхүүжилт авах хэрэгцээ, шаардлагатай тулгардаг. Гадаад санхүүжилтийн эх үүсвэр нь зээл, тусламж, хөрөнгө оруулалтын хэлбэртэй байх бөгөөд дийлэнх улс орнуудын гадаад санхүүжилтийн цөм хэсгийг гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) бүрдүүлдэг болжээ. Үүнд, сүүлийн 20-30 жилд улс орнуудын хөрөнгийн урсгалд тавих хязгаарлалт суларч, худалдааны нээлттэй байдал, олон улсын байгууллагуудын тоо нэмэгдсэн зэрэг нь эерэгээр нөлөөлсөн байна.

Тодорхойлолт: Гадаадын шууд хөрөнгө оруулалт

ОУВС-ийн аргачлалд “Гадаадын шууд хөрөнгө оруулалт” гэж тухайн аж ахуйн нэгжийн удирдлагад нөлөөлөхүйц эсвэл шууд удирдах эрх бүхий хэмжээний хөрөнгө (дүрмийн сангийн 10%-иас дээш) оруулахыг хэлдэг бол Монгол Улсын “Хөрөнгө оруулалтын тухай хууль”-д ААН-ын хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа бөгөөд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 100 мянган ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш дүнтэй бол гадаадын шууд хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гэдэг байна. ГШХО нь (i) дүрмийн санд оруулсан хувь эзэмшил, (ii) хөрөнгө оруулалтын өгөөжөөс ашигласан санхүүжилт буюу дахин хөрөнгө оруулалт, (iii) толгой болон хамаарал бүхий компаниас олгосон санхүүжилт буюу компани хоорондын зээллэг гэсэн гурван хэлбэртэй байдаг.

Онолын хувьд ГШХО нь тухайн салбарын болон бусад бэлтгэн нийлүүлэгч салбарын үйлдвэрлэл, ажил эрхлэлтийг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтийг дэмжихээс гадна хөрөнгө оруулалтыг дагаж орж ирэх мэргэшсэн боловсон хүчин, технологи нь хөдөлмөрийн

стандартыг дотоодод бүрдүүлж, бүтээмжийг сайжруулснаар эдийн засгийн өсөлтийг дэмжих нэг гол хүчин зүйл болдог. Гэхдээ тухайн улсын эдийн засгийн онцлог, санхүүгийн зах зээлийн хөгжил, институцийн орчин, хөрөнгө оруулалт голлон татсан салбар зэрэг маш олон хүчин зүйлээс шалтгаалж хөрөнгө оруулалт нь эдийн засагт зарим тохиолдолд сөргөөр нөлөөлөх бөгөөд дотоодын хөрөнгө оруулагчдыг шахан гаргах, эдийн засгийг хэт халаах зэрэг таагүй үр дагавар учруулдаг байна (Slesman, Baharumshah, & Wohar, 2015). Өөрөөр хэлбэл, энэ нь зарим улсын хувьд ГШХО-аас үүсэх эерэг нөлөөг шингээж чадах хүний нөөц, санхүүгийн зах зээл, институцтай байдаг бол зарим улсын хувьд эдгээр хүчин зүйлс хараахан бүрдээгүйтэй холбоотой. Тухайлбал, Мексик, Уругвай, Индонез, Польш болон зарим хөгжиж буй улсуудын хувьд хийгдсэн судалгаагаар ГШХО нь технологийн дам нөлөөгөөр бүтээмж болон эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөтэйг тогтоосон бол БНХАУ, Марокко зэрэг улсуудын хувьд хийгдсэн судалгаагаар ГШХО нь богино хугацаанд сөрөг нөлөөтэй гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Тиймээс улс орнууд ГШХО-ын өөрийн улсын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлж өөрийн улсын онцлогт нийцсэн ялгаатай бодлого баримталдаг байна. Тухайлбал, Сингапур улс дотоодын хүний нөөцийг чадавхжуулж, өрсөлдөөнийг нэмэгдүүлэхийн тулд гадаадын хөрөнгө оруулагчдад татварын таатай бодлого хэрэгжүүлдэг бол 20 дугаар зууны сүүлийн хагаст эрчимтэй хөгжсөн Азийн зарим улс ГШХО дотоодын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж, технологийн дэвшлийг хязгаарлаж байна гэж үзэж энэ төрлийн хөрөнгийн урсгалыг хязгаарлах бодлого хэрэгжүүлсэн байна (Wong, 2003; Aw, 2003).


¹ Судалгаа, статистикийн газрын, статистикийн хэлтсийн эдийн засагч (Монголбанк)

² Судалгаа, статистикийн газрын Судалгааны хэлтсийн эдийн засагч (Монголбанк)

Монгол Улсын хувьд 2010 он хүртэл ГШХО харьцангуй бага дүнтэй байсан ч гадаад зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ өссөн, томоохон төслийн хөрөнгө оруулалтын гэрээ хийгдсэнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж эхэлсэн. Тухайлбал, 2005-2009 оны хооронд 3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт орж ирж байсан бол 2010-2014 оны хооронд 18 тэрбум ам.доллар болжээ. Түүнээс хойш өсөлтийн хэмжээ саарч хөрөнгө оруулалтын хэмжээ харьцангуй тогтворжсон ч шууд хөрөнгө оруулалтын дүн нийт гадаад санхүүжилтийн эх үүсвэрийн голлох хувийг бүрдүүлсэн хэвээр байна. Тухайлбал, 2020 оны 2 дугаар улирлын байдлаар Монгол Улсын гадаадаас татсан нийт санхүүжилтийн үлдэгдэл 43.3 тэрбум ам.доллар, үүний 54% буюу 23.5 тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалт байна. Санхүүжилтийн хэлбэрийн хувьд ГШХО-ын үлдэгдлийн 53% буюу 12.4 тэрбум ам.доллар нь хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт бол үлдсэн 47% буюу 10 тэрбум ам.доллар нь толгой компаниасаа авсан зээл буюу гадаад өрийг нэмэгдүүлсэн эх үүсвэр байна.

ГШХО-ыг эдийн засгийн салбараар нь харвал 2020 оны 2 дугаар улирлын байдлаар нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 73% уул уурхайн салбарт, 8% худалдааны салбарт, 5% санхүү даатгалын салбарт, 4% барилгын салбарт, үлдсэн 11% үйлдвэрлэл, үйлчилгээний бусад салбарт хийгдсэн байна. Тэгвэл ГШХО-ын урсгалыг уул уурхайн томоохон төсөл болон бусад аж ахуйн нэгжээр нь харвал адил төстэй байх бөгөөд хөрөнгө оруулагч улсын хувьд дийлэнх буюу 92%-ийг Канад улсаас татсан хөрөнгө эзэлж байна.


Зураг 1. МУ-д орсон ГШХО үлдэгдэл, ДНБ-ий харьцаа




Зураг 2: ГШХО үлдэгдэл, эдийн засгийн салбараар



Зураг 3. ГШХО орох урсгал



Зураг 4. ГШХО үлдэгдэл, хөрөнгө оруулагч улсаар



Эх сурвалж: Монголбанк, Төлбөрийн тэнцэл, Гадаад хөрөнгө оруулалтын позиц, ГШХО-ын судалгаа

Манай улсад ГШХО-ын дотоодын эдийн засагт үзүүлж буй нөлөөг судалсан ажлуудад ГШХО-ын технологи, тоног төхөөрөмж, хүний нөөцөд үзүүлэх эерэг дам нөлөө нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмждэг, гадаадын шууд хөрөнгө оруулалтын тогтвортой байдал нь эдийн засгийн тогтвортой байдалд чухал нөлөөтэй болохыг онцолжээ. Тодруулбал, Д.Ган-Очир (2005) ГШХО/ДНБ-ий харьцаа 1 нэгж хувиар өсөхөд ДНБ 1.87 хувиар өсдөг, Д.Мөнхцэцэг болон П.Гантөмөр нар (2015) ГШХО-ын өсөлт нь 2011 оны эдийн засгийн өсөлтөд хамгийн ихээр нөлөөлсөн, ГШХО-ын нэг хувийн өсөлтөд уул уурхайн салбар, бөөний ба жижиглэн худалдаа, автомашины засварын салбарын үйлдвэрлэл хамгийн ихээр өсдөг гэсэн бол Д.Ган-Очир болон Л.Даваажаргал (2019) нар бодит ДНБ-ийн өөрчлөлтийн 20 орчим хувийг гадаадын шууд хөрөнгө оруулалтын шок бүрдүүлдэг гэжээ.

Гэхдээ бүтцийн хувьд задалж харахад, Монгол Улсад орсон ГШХО голчлон уул уурхайн салбарт чиглэсэн нь түүхий эдийн үнээс хараат болох эрсдэлийг нэмэгдүүлээд зогсохгүй нийт хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг Канад, БНХАУ, Сингапур, Люксембург, Хонг-Конг улсын хөрөнгө оруулагч нар бүрдүүлж байгаа нь цөөн хэдэн улс, томоохон корпорацийн үйл ажиллагаа буюу гадаад зах зээлээс хамааралтай байдлыг бий болгож байна. Тиймээс ГШХО-ыг дэмжих бодлого хэрэгжүүлэхээс гадна хөрөнгө оруулалт татаж буй салбарыг төрөлжүүлж, хөрөнгө оруулагчдын тоог нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Дэлхийн банк (2018)-ны судалгаагаар Монгол Улс нь ГШХО-ын хууль, зохицуулалтын түвшинд нээлттэй боловч бусад улсуудтай харьцуулахад хөрөнгө оруулалтын урсгал хангалтгүй байна, ГШХО-ыг татахад ганц бодлогын хувьд нээлттэй байх нь хангалтгүй ба хөрөнгө оруулалтын орчин нь мөн хязгаарлалт болдог. Хөрөнгө оруулагч нарын хувьд сайн засаглал, ил тод хууль, эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн урьдчилан таамаглаж болохуйц тогтвортой байдал, гэрээний хэрэгжилт зэрэг нь маш чухал хүчин зүйл юм. Энэ нь ч олон тоон мэдээллээс харагддаг. Жишээлбэл, бизнес эрхлэхэд хэр таатай байгаагаар нь улс орнуудыг эрэмбэлэн харуулдаг Дэлхийн Банкны 'Doing Business' жагсаалтад сүүлийн 5 жил Монгол Улсын эзлэх байр 22-оор ухарч, 2019 онд 81 дүгээрт очоод байна. Тиймээс, хөрөнгө оруулагч нарыг татахын тулд дэмжих

боломжтой салбаруудыг тодорхойлж, холбогдох дэд бүтцийг үе шаттайгаар бүрдүүлэх, нийлүүлэлтийн гинжин сувгийг цогцоор нь хөгжүүлэх, нэгдсэн сувгаар хөрөнгө оруулалтыг сурталчлах, компани ажил явуулах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн ойрын жилүүдэд манай орны хувьд гадаад зээл, бондын төлбөрүүд төлөгдөх, томоохон төсөл хөтөлбөрийг өрийн бус санхүүгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага их байгаа тул хөрөнгө оруулалтыг урин дуудах, төрөлжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх нэн шаардлагатай байна. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр нь зээлийн санхүүжилттэй харьцуулахад эрсдэл бага, өрийн дарамтыг нэмэгдүүлэхгүйн дээр дэвшилтэт технологи, арга барилыг нэвтрүүлдэг учир шаардлагатай салбарт, зөв бодлогоор татсан тохиолдолд цаашдын эдийн засгийн тогтвортой байдалд олон талаар эерэгээр нөлөөлөх юм.

МОНГОЛБАНК 9 ДҮГЭЭР САРД 2.3 ТОНН ҮНЭТ МЕТАЛЛ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанк 2020 оны 9 дүгээр сард 2.3 тн үнэт металл худалдан авч, оны эхнээс өссөн дүнгээр нийт 17.1 тн үнэт металл худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6.0 тн-р өссөн үзүүлэлт юм. Монголбанкны нийт худалдан авсан 17.1 тн үнэт металлын 15.4 тн нь алт, 1.7 тн нь цагаан мөнгө байна.

2020 оны 9 дүгээр сарын хувьд Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 123.9 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 154.5 кг үнэт металл худалдан аваад байна. Он гарснаас хойш орон нутаг дахь Монголбанкны 2 хэлтэс нийт 1.4 тн үнэт металл худалдан авлаа.

Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж үнэ 2020 оны 9 дүгээр сард 176,494.48 төгрөг байлаа.



График 1. 2018-2020 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын сарын мэдээ (кг)




График 2. 1990-2020 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын хэмжээ (тонн)



График 3. 2020 оны 9 дүгээр сард Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг/грамм)

ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлсэнээс хойш 2020/09/30-ны хооронд 2,917.7 сая ам.долларын болон 113.4 сая юанийн нийт 1703 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.



МОНГОЛБАНК

Монголбанк юу хийдэг вэ?

Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд зааснаар
Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн
тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

Мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх



Монголбанк төрийн мөнгөний бодлогыг
боловсруулж, хэрэгжүүлнэ.



Монголбанк дараагийн жилд баримтлах төрийн
мөнгөний бодлогыг боловсруулж, жил бүрийн 10
дугаар сарын 1-ний дотор Үлсын Их Хуралд өргөн
барина.



Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах



Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, гүйлгээнээс татна.



Мөнгөн тэмдэгт үйлдвэрлэх, тээвэрлэх,
хадгалах, түүний нөөцийг бий болгох, хүчин төгөлдөр
эсэхийг тодорхойлох, гэмтэж муудсаныг солих, устгах
ажлыг эрхлэн зохион байгуулна.



Гэмтэж муудсан мөнгөн тэмдэгт солих журмыг
Монголбанк тогтооно.

Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх



Төрийн сангийн нэгдсэн дансыг Сангийн сайдын
хүсэлтээр өөр дээрээ байршуулж, гүйлгээг хийнэ.



Засгийн газрын хүсэлтээр Засгийн газрын үнэт
цаасыг бусад этгээдэд зуучлан борлуулна.



Хууль тогтоомжид нийцсэн зуучлалын бусад үйл
ажиллагаа эрхэлнэ.



Банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих



Банкны тогтолцооны найдвартай байдлыг
бэхжүүлэх зорилгоор банк байгуулах зөвшөөрөл
банкнд олгоно.



Үйл ажиллагааг нь зохицуулахтай холбогдсон дүрэм,
журам шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.



Хадгаламжийн даатгалын корпорацийн үйл
ажиллагаанд хяналт тавина.

Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах



Банк хоорондын төлбөр тооцоог Монголбанкн дахь
тухайн банкны харилцах дансаар дамжуулан
гүйцэтгэнэ.



Үндэсний төлбөрийн систем, түүний үйл
ажиллагаанд холбогдсон харилцааг Үндэсний
төлбөрийн системийн тухай хуулиар зохицуулна.



Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах



Монголбанк эзэмшин, удирдаж байгаа гадаад
валютын улсын нөөцийн гадаад төлбөрийг түргэн
гүйцэтгэх чадвар, найдвартай байдлыг хангана.



Монголбанк чөлөөтэй хөрвөдөг гадаад валют, түүнтэй
адилгах хэрэгслийг төгрөгөөр худалдах, худалдаж
авахдаа төгрөгийн тогтвортой байдлыг хангана.

Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах



Зохистой харьцааг хангуулах хяналт шалгалтыг
хэрэглэгчийг хамгаалах хяналттай хослуулна.



Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах "Их 20"-ын 11
зарчмыг нэвтрүүлнэ.



"Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хууль"-д
нэмэлт өөрчлөлт оруулна.



Макро зохистой бодлого хэрэгжүүлэх



Мөнгөний бодлогын хэрэгжилт болон банк,
санхүүгийн эрсдэлийг тодорхойлох, урьдчилан
сэргийлэх зорилгоор тус бодлогыг боловсруулна.



Макро зохистой бодлогыг заавал байлгах нөөц зэрэг
хэрэгслүүдээс ашиглан хэрэгжүүлнэ.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО УРАГШАА ХАРСАН ШИЙДВЭР ГАРГАХЫГ ЗОРЬДОГ

Монголбанкны
Мөнгөний
бодлогын
хорооны
гишүүн
Ц.Мөнхбаяртай
ярилцлаа.



Монголбанк 2018 онд Мөнгөний бодлогын зөвлөлийг хороо болгож, бүтцийг нь өөрчлөн, шинэчлэн байгуулсан нь ямар ялгарах онцлогтой вэ? Мөнгөний бодлогын хараат бус байдлыг хангахад Мөнгөний бодлогын хороо ямар давуу талыг бий болгодог вэ?

Төв банкны хараат бус байдлыг хэмжихдээ зорилгодоо хүрэх бодлогын хэрэгслийг сонгох, хэрэгжүүлэх эрх нь хэр хангагдсан байдаг бэ гэдгээр тодорхойлдог. Жил бүр УИХ-аас Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг баталдаг. Харин тэр бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой бодлогын шийдвэрийг Мөнгөний бодлогын хороо гаргаж, Монголбанк хэрэгжүүлдэг. Энэ зохицуулалтыг тусгасан Төв банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт 2018.04.01-ний өдрөөс эхлэн хэрэгжсэн. Үүнээс өмнө Монголбанкны Ерөнхийлөгч гишүүдийг нь томилдог Мөнгөний бодлогын зөвлөлтэй байсан. Энэ зөвлөл нь эцсийн шийдвэрийг бие даан гаргах эрхтэй Ерөнхийлөгчид зөвхөн зөвлөдөг байсан. Харин сая хэлсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр, УИХ-аас гишүүдийг нь томилдог Мөнгөний бодлогын хороотой болсон. Тэгэхээр яг ижил субъектээс томилогдож байгаа гэдэг утгаараа Мөнгөний бодлогын хорооны гишүүд Төв банкны Мөнгөний бодлогын газраас танилцуулсан саналыг хэлэлцээд, бие даан, олонхийн саналаар шийдвэр гаргадаг. Тэгэхээр засаглалын шинэчлэл хийгдэж, Төв банкны хараат бус байдал сайжирсан гэсэн үг.

Шинээр байгуулагдсан Мөнгөний бодлогын хороо байгуулагдсанаасаа хойш амаргүй шийдвэрүүдийг гаргасан гэж бодож байна. Өнгөрсөн хугацаан дахь мөнгөний бодлогын шийдвэрүүдийн үр дүнтэй байдлыг та хэрхэн дүгнэж байна вэ?

Мөнгөний бодлогын хорооны анхны хурал 2018 оны 6 дугаар сарын 15-нд болж байсан. Тухайн үед хоёр шийдвэр гаргасан. Нэгдүгээрт, мөнгөний бодлогын хүүг хэвээр хадгалах, хоёрдугаарт, хэрэглээний зээлд өр-орлогын харьцааг шинэчлэн тогтоох тухай байсан. Эдгээр шийдвэр нь өмнөхтэй харьцуулбал санхүүгийн тогтвортой байдлыг хангахад илүү чиглэсэн шийдвэр болсон. Хэдийгээр тухайн үед хэрэглээний зээл яг эдийн засагт дарамт үзүүлээгүй байсан ч ирээдүйд өрхийн секторын өрийн дарамтыг нэмэгдүүлэх хандлагатай байна гэж үзсэнээр шийдвэр гарч байлаа. Өнөөдөр энэ шийдвэр нь зөв байсныг статистик тоо мэдээлэл харуулж байна. Хэрэв өрийн дарамтыг бууруулаагүй бол өнөөдөр илүү их хүндрэлтэй тулгарах байсан. Ер нь бодлогын шийдвэр гаргахад тодорхой бус байдал их байдаг. Хамгийн сүүлд 9 дүгээр сард Мөнгөний бодлогын хороо хуралдахад “Бодлогын санал” гэдэг нэг нүүр танилцуулгад байгаа 14-15 өгүүлбэрийн 7-8 нь “тодорхой бус байна” гэж байсан байх жишээний. Тодорхой бус байдал сүүлийн 2-3 жилд ер нь л арилаагүй. Зөвхөн цар тахалтай холбоотой ч бус ер нь дэлхийн эдийн засаг дахь тодорхой бус байдал хэвээр хадгалагдаж байна. Өмнө нь их гүрнүүдийн

худалдааны дайн зэрэг тодорхой бус байдал их байсан бол 2020 он гарснаас хойш цар тахалтай холбоотойгоор тодорхой бус байдал улам л нэмэгдсэн. Тэгэхээр ийм нөхцөл байдалд ирээдүйг харсан шийдвэр гаргана гэдэг амаргүй. Бид улирал болгон хуралддаг. Хурал болгоноор төсөөлөл шинэчлэгддэг бөгөөд тухайн төсөөлөлд үндэслээд бодлогын шийдвэрийг гаргадаг. Өнгөрсөн жилүүдэд 5-6 хурал дарааллаад бодлогын хүүг хэвээр үлдээсэн шүү дээ. Тэр маань юуг илэрхийлж байна вэ гэхээр тодорхой бус байдал сайжраагүй л гэсэн үг. Харин 2020 он гарснаас хойш гурван ч удаа бодлогын хүүг бууруулсан нь цар тахлын үед эдийн засаг, санхүүгийн системийн тогтвортой байдлыг дэмжих зорилготой байсан.

Олон улсын Төв банкуудын гаргаж байгаа шийдвэрүүдийг мөнгөний бодлогын шийдвэртээ хэрхэн харгалзан үзэж байна вэ, ялангуяа, Ковид-19 цар тахлын үед бодлогын хүүгээ бууруулах шийдвэр хэд хэдэн удаа гаргалаа шүү дээ?

Манайх шиг жижиг, нээлттэй улсын хувьд гадаад зах зээлийн нөхцөл байдал маш чухал. Ялангуяа урд хөрш БНХАУ-ын эдийн засгийн төлөв байдал, гадаад зах зээлийн нөхцөл байдал их нөлөөтэй. Өмнө нь бид гадаад зах зээл дээр бонд гаргадаггүй, зээл авдаггүй байх үед худалдааны нөлөө илүү хүчтэй байсан. Сүүлийн үед бид олон улсын зах зээл дээр хэд хэдэн бонд гаргачихсан, дахин санхүүжилтийн хэрэгцээ их байгаа үед санхүүгийн зах зээл дээрх өөрчлөлт, ялангуяа бусад Төв банкуудын зах зээлдээ нийлүүлж байгаа уламжлалт бус бодлогын нөлөө хүчтэй болсон. Худалдааны хувьд мэдээж Хятадын эдийн засгийн өсөлт буюу дотоод эрэлт нь манай экспортын бүтээгдэхүүний үнэд шууд нөлөөлөх учраас байнга харж байдаг. Хамгийн сүүлд болсон хурлаар Хятадын эдийн засгийн төлөв байдлын төсөөлөл нааштай байсан нь бодлогын хүүг бууруулахад эерэгээр нөлөөлсөн.

Төв банкууд мөнгөний бодлогын уламжлалт бус арга хэрэгслийг их хэрэгжүүлж байна. Монголбанкны хувьд ч бас цаашдаа уламжлалт бус бодлогын арга хэрэгсэл рүү зорих уу?

Дэлхийн Төв банкууд уламжлалт бус бодлого руу орж байгаа. Гэхдээ үүн дээр ОУВС-аас хоёр зүйл зөвлөсөн

байсан. Уламжлалт бус бодлого үр дүнтэй байхын тулд нэгдүгээрт, санхүүгийн зах зээлийн хөгжил чухал юм байна. Хоёрдугаарт, тухайн улсын засаглал буюу институцийн чадавх. Энэ хоёр үзүүлэлт нь уламжлалт бус бодлого үр дүнтэй хэрэгжих үү гэдэг дээр их чухал нөлөөтэй гэсэн байгаа. Энэ агуулгаараа бид ч бас их анхаарал хандуулж байна. Хэдийгээр уламжлалт бус бодлогын зорилго, бодлого зөв байх хэдий ч, хэрэгжилт дээрээ сайн анхаарахгүй бол эдийн засгийнхаа тэнцвэртэй хөгжил, зах зээлийн үр ашигт сөргөөр нөлөөлж болзошгүй. Мөнгөний бодлогын хорооны сүүлийн хурлаар уламжлалт бус бодлогын хүрээнд Төв банкнаас репо санхүүжилтийн журамд өөрчлөлт оруулах замаар банкуудын тодорхой секторт олгосон зээлээр баталгаажсан активыг репо хэлцлээр 2 хүртлэх жилийн хугацаатай авах эрхийг нээж өгсөн. Энэ хүрээнд бэлтгэл ажил хангагдаж байгаа. Мөнгөний бодлогын хүүг бууруулсан шийдвэр 2-4 улирлын дараа эдийн засаг, санхүүгийн системдээ нөлөөлж эхэлдэг. Харин репо санхүүжилтээр банкуудын активыг худалдан авснаар илүү богино хугацаанд банкуудын зээл гаргах сонирхлыг нэмэгдүүлэх буюу санхүүгийн зуучлалыг сэргээх, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах зорилготой. Энэ нь уул уурхайн бус салбарын экспортыг дэмжихийн зэрэгцээ дотоодын зээл олголтыг нэмэгдүүлнэ. Наймдугаар сарын байдлаар зээл олголт өмнөх жилтэйгээ харьцуулахад 5 хувиар буурсан байгаа. Тэгэхээр бодит секторыг дэмжих хэрэгцээ өндөр байна гэсэн үг.

Хоёр жилийн хугацаатай репо санхүүжилт нэвтрүүлэх шийдвэр нь Мөнгөний бодлогын хорооны гишүүдийн дунд хэр их мэтгэлцээн үүсгэсэн бэ, зөрүүтэй байр суурь байсан уу?

Хоёр зүйл яригдсан л даа. Эхнийх нь энэ хоёр алхмыг зэрэг явуулах хэрэгцээ байна уу, үгүй юу гэдэг асуудал. Бодлогын хүүг дарааллан буулгасан байгаагийн үр дүн гарч амжаагүй байгаа. Тэгэхээр өмнөх шийдвэрүүдийнхээ үр дүнг харах хэрэгтэй юу гэх асуудал. Хоёрдугаарт, энэ шийдвэрийн зорилго мэдээж ойлгомжтой. Гэхдээ хэрэгжүүлэхдээ маш болгоомжтой байхгүй бол зах зээл дээр тэгш бус өрсөлдөөнийг бий болгох вий гэсэн болгоомжлол байгаа. Аливаа төрийн бодлогыг хэрэгжүүлэхдээ үр ашиг, тэгш байдлын хүрээнд оновчтой сонголтыг хийхгүй бол зах зээл дээр гажуудал бий болгох эрсдэлтэй. Гэхдээ хорооны

хурлаар нэгэнт бодит сектор агшчихсан, дотоодын зах зээл дэх албан бус секторт ажил эрхлэлт бидний төсөөлж байснаас ч ихээр хумигдсан гэж үзсэн учраас бодлогын хүүг бууруулахаас гадна репо санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн.

Бодлогын шийдвэрийн үр нөлөөтэй байдлын талаар та дурдлаа. Тэгэхээр мөнгөний бодлогын шийдвэрийн үр нөлөөтэй байдлыг хангахад Засгийн газрын төсвийн бодлого хүндрэл учруулах тал байдаг. Энэ талаар?

Төсвийн хувьд өнгөрсөн оны мөн үед 500 тэрбум төгрөгийн ашигтай байсан бол одоогийн байдлаар 2 их наяд гаруй төгрөгийн алдагдалтай байна. Энэхүү алдагдал нь төсвийн гадаад, дотоод өрийг нэмэгдүүлдэг. Өр нэмэгдэх нь зээлийн хүүгээр дамжаад төсвийн зардлыг нэмэгдүүлэх сөрөг нөлөөтэй. Мөн дунд хугацаандаа зээлжих зэрэглэл муудах зэргээр шууд бусаар эдийн засгийн бусад салбартаа сөргөөр нөлөөлдөг. Төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор дотоодын банкны системээсээ зээл авбал, бидний хэлдгээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг шахан гаргах үзэгдэлд хүргэдэг. Өөрөөр хэлбэл, мөнгөний бодлогоор хувийн хэвшлийг дэмжих орон зайг хумидаг гэсэн үг. Гадаад талаасаа өндөр өртөгтэй бонд гаргалаа гэхэд зөв зарцуулахгүй бол тэрхүү өрийн дарамт нь эргээд өрх гэр, татвар төлөгчдийн нуруунд ачаа болдог. Иймд аль ч агуулгаар харсан төсвийн алдагдлыг бууруулах шаардлагатай. Мөнгөний бодлогын сүүлийн шийдвэрийг гаргахдаа бид төсвийн нөхцөл байдал ирэх оноос харьцангуй сайжирна гэсэн төсөөлөлд үндэслэсэн.

Монголбанкнаас дунд хугацаанд инфляцын зорилтыг 6 орчим хувьд тогтворжуулахыг зорьж байна. Тэгэхээр томоохон эдийн засгуудын хувьд аль болох олон жилийн дараах нөхцөл байдлыг харж, эдийн засгийнхаа хүлээлтийг удирдахыг зорьдог. Энэ чиглэлд чадавч ямар байна гэж үзэж байна вэ?

Монголбанк макро эдийн засгийн үндсэн загваруудыг олон жил хөгжүүлж ирсэн. Байнга сайжруулж байдаг. Загвар дээр үндэслэн төсөөллийг боловсруулж, "expert judgement" буюу бодит байдал дээр гарч болох зарим

нөхцөл байдлыг загвартаа оруулж, залруулснаар бодлогын саналыг боловсруулдаг. Богино, дунд, урт хугацааны загварчлал бүгд өөр өөр. Тэр бүгдийг сайжруулахад Төв банкны загварчлалын нэгж маш их анхаарч ажилладаг. Яг манай улсын хувьд хүндрэлтэй зүйл юу вэ гэхээр жижиг, нээлттэй, уул уурхайд суурилсан эдийн засгийн бүтэцтэй байгаад байна. Ийм эдийн засагт аливаа өөрчлөлт маш богино хугацаанд ороод, богино хугацаанд гардаг. Та бүхэн санаж байгаа бол 2010, 2011 онд уул уурхайн салбар сэргэхэд тэр өөрчлөлт эдийн засагт ямар хурдан шингэж, бүр "халалтад" очсон билээ дээ. Тэр үед төгрөгийн ханшаа хэт чангарахаас яаж сэргийлэх вэ гэдэг асуудлыг ярьж байсан. Манай эдийн засаг төрөлжилт багатай учраас өөрчлөлтийг маш хурдтай авдаг. Мөнгөний бодлого эдийн засгийн эрэлтийн талын зохицуулалтуудыг хийдэг. Үүний тулд богино хугацааны загваруудад илүү их анхаарал хандуулдаг. Харин Засгийн газар дунд, урт хугацааны хөгжлийн асуудалд анхаарал хандуулдаг учраас тэр талын загваруудаа илүү их хөгжүүлдэг байх.

Төв банк эдийн засгийн бодлогын хувьд богино, дунд гэхээсээ илүү урт хугацааны тогтвортой байдлыг хангах хэрэгтэй байх?

Эдийн засгийн онолоор эрэлт богино хугацаанд үнээ дагаад хөдөлдөг. Харин нийлүүлэлт урт хугацаанд буюу технологийн шийдэл болон бусад хүчин зүйлээс хамаарч хөдөлдөг. Энгийн нэг загвар дээр графикийг зурахад эрэлтийн муруй богино хугацаанд хөдөлдөг, харин нийлүүлэлтийн муруй хөдөлдөггүй. Тэгэхээр Төв банкны хувьд эрэлт талаа удирдаж байдаг. Харин Засгийн газар нийлүүлэлтийн талын асуудал буюу урт хугацааны хөгжлийн дэд бүтцээ сайжруулах зэрэгт анхаарал хандуулдаг. Аливаа бодлогыг хэрэгжүүлэхэд зах зээлд оролцогчдын мэдлэг, боловсрол чухал гэдэг утгаараа санхүүгийн боловсролд анхаарал хандуулж байна. Гэсэн хэдий ч нийлүүлэлтийн асуудалд Засгийн газрын түвшинд нэгдсэн бодлогоор тасралтгүй, тогтвортой, ахиц гаргасан чиглэлд явж байж л энэ шийдэгдэнэ. Манай нэг дутагдал нь бүтцийн өөрчлөлтийн бодлогыг нэг их ярьдаггүй. Мөнгөний бодлого болон төсвийн бодлого гэж ярьдаг. Сангийн бодлого гэж ярьдаггүй. Өөрөөр хэлбэл, төсвийн бодлого буюу төсвөө л хийх талаар ярьж байна гэсэн үг. Түүнээс биш сангийн бодлого буюу эдийн засгийг

тогтворжуулах чиглэлд төсвийг ашиглах талаар ярьдаггүй. Хоёрдугаарт, бүтцийн өөрчлөлтийн бодлого буюу эдийн засгийн бүтцийг зөв чиглэлд оруулах, хувийн хэвшил үр ашигтай, өрсөлдөөнтэй ажиллах зах зээлийн орчныг бий болгох бодлогодоо төдийлөн анхаардаггүй. Тэгэхээр сангийн бодлого болон бүтцийн өөрчлөлтийн бодлого гэсэн хоёр бодлогыг бид зөв авч явбал, эдийн засгийн бүтэц сайжирна. Түүнийг дагаад эдийн засгийн тогтвортой хөгжилд хүрнэ.

Эдийн засгийг төрөлжүүлэх, бүтцийн өөрчлөлт хийх асуудал байнга л яригддаг. Төв банк ч бас бодлогын томоохон институцийн хувьд энэ талаар дуугардаг. Мөнгөний бодлогын шийдвэртээ энэ асуудлыг хэрхэн хөндөж оруулж байна вэ?

Нийлүүлэлт талын асуудлууд сайжирснаар мөнгөний бодлогын хэрэгжилт, түүний үр дүн илүү сайжирна. Зах зээл нь сайн болчихвол мөнгөний бодлогын шилжих суваг илүү хурдтай, үр ашигтай ажилласнаар үр дүн нь сайжрах боломжтой. Энэ хүрээнд Төв банкны зүгээс бодлогын судалгааг хийгээд, Засгийн газарт зөвлөмж хүргүүлдэг. Төв банкны мөнгөний бодлогын судалгаанаас гадна эдийн засгийн суурь судалгааг хийж, холбогдох байгууллагуудад зөвлөмж өгөх зорилготой Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнг тусад нь байгуулсан. Суурь судалгаанд үндэслэсэн оновчтой эдийн засгийн бодлого хэрэгжүүлснээр мөнгөний бодлогын шийдвэрийн үр дүнтэй байдал нэмэгдэх юм.


Төгсгөлд нь асуухад Монголбанк макро зохистой бодлогыг хэрэгжүүлж байгаа. Үүний нэг үр нөлөө нь макро эдийн засаг, санхүүгийн системийг зөв гольдролд нь оруулахад чухал уу?

Макро зохистой бодлого гэж санхүүгийн нийт системийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн бодлогын цогц арга хэмжээг хэлдэг. Гол онцлог нь нэгдүгээрт, шууд нөлөөтэй. Хоёрдугаарт, зохистой түвшин рүү хүргэх буюу эрсдэл хуримтлагдахаас сэргийлдэг тул мөчлөг угтаж авч хэрэгжүүлдэг хэрэгсэл. “Макро” гэж байгаа учраас системийн хэмжээг хамарч байна. Жишээ нь өрхийн сектор дээр зохицуулалт хийж байна. “Зохистой” гэж байгаа учраас тухайн үзүүлэлт өөрөө ямар түвшинд байвал зохистой вэ гэдгийг эдийн засгийн загвар дээр

үндэслээд тодорхойлж байгаа. Хүн өрхийн орлогынхоо 80-90 хувийг хэрэглээндээ зарцуулбал, үлдсэн орлого нь боловсрол, эрүүл мэнд, хуримтлалд хүрэхгүй. Гэтэл үүнийг иргэд өдөр тутмын амьдралдаа тэр бүр анзаарч, мэддэггүй. Тийм учраас өрхийн секторын хувьд нийт орлогынхоо 70 гаруй хувийг өрөө төлөхөд зарцуулж болохгүй. Харин 50 хувийг нь зарцуулаад, үлдсэн хувиа бусад хэрэгцээндээ зарцуулах нь эдийн засгийн тогтвортой байдал, нийгмийн хөгжилд эерэг нөлөөлнө гэдгийг судалгаагаар тогтоосон. Уг судалгааны дагуу өрхийн өрийн дарамтыг зохистой түвшин рүү хүргэх зорилгоор бодлогын шийдвэр гарсан. Шийдвэрийн үр дүн ч гарч байгаа. Өмнө нь өрхүүд 80-90 хувийг өрөндөө төлдөг байсан бол одоо 50-60 хувь болж буурч зохистой түвшин рүүгээ ойртож байна гэсэн үг. Тэгж байж, санхүүгийн тогтвортой байдал буюу тэнцвэр хангагдана. Макро зохистой бодлого нь бусад улс орны хувьд ч бас байдаг л жишиг.

Ярилцсан: Д.Ариунаа
(ОНБМТ-ийн Ахлах мэргэжилтэн)

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ. ДОЛЛАРААР, 25/IX ӨДРИЙН БАЙДЛААР)



ДЭЛХИЙ НИЙТИЙН ЦАР ТАХАЛТАЙ ХИЙЖ БУЙ ТЭМЦЭЛ:

Мөнгөний бодлогын шийдвэрүүд¹

Олон улсын зах зээл дээрх газрын тосны үнэ тогтворжиж, инфляц өсч эхэлж байгаа нь дэлхийн эдийн засаг эргэн сэргэх дохио болж байна.

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

Коронавирус (Ковид-19) цар тахал нь дэлхийн хэмжээнд сөрөг нөлөө үзүүлж хүн төрөлхтний амь нас, эрүүл мэндэд төдийгүй эдийн засгийг бүхэлд нь эрсдэлд учруулаад байгаа билээ. Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (ЭЗХАБ)-аас Дэлхийн Эдийн Засгийн Төлөв байдлын тоймыг 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр танилцуулсан. Уг тоймд дурьдсанаар “Энэ онд Евро бүсийн эдийн засаг (-)7.9%-иар, дэлхийн эдийн засаг (-) 4.5%-иар агших төлөвтэй байна” гэжээ. Энэхүү гэнэтийн шокыг даван туулахын тулд төсөв, мөнгөний бодлогоор зогсонги байдалд ороод байгаа эдийн засгийг дэмжиж, хямарлыг зөөллөх бодлого баримтлах нь чухал юм. Дэлхийн улс орнуудын Засгийн газар, Төв банкууд ч энэ чиглэлд арга хэмжээнүүдийг

Улс орнуудын бодит ДНБ-ий өсөлт

	2019	2020	2021		2019	2020	2021
World	2.6	-4.5	5.0	G20	2.9	-4.1	5.7
Australia	1.8	-4.1	2.5	Argentina	-2.1	-11.2	3.2
Canada	1.7	-5.8	4.0	Brazil	1.1	-6.5	3.6
Euro area	1.3	-7.9	5.1	China	6.1	1.8	8.0
Germany	0.6	-5.4	4.6	India	4.2	-10.2	10.7
France	1.5	-9.5	5.8	Indonesia	5.0	-3.3	5.3
Italy	0.3	-10.5	5.4	Mexico	-0.3	-10.2	3.0
Japan	0.7	-5.8	1.5	Russia	1.4	-7.3	5.0
Korea	2.0	-1.0	3.1	Saudi Arabia	0.4	-6.8	3.2
United Kingdom	1.5	-10.1	7.6	South Africa	0.1	-11.5	1.4
United States	2.2	-3.8	4.0	Turkey	0.9	-2.9	3.0

¹ Э.Золзаяа (ОНБМТ-ийн мэргэжилтэн)


АНУ

- Бодлогын хүү 0-0.25%
- Төрийн сангийн бонд, моргежоор баталгаажсан үнэт цаасыг үргэлжлүүлэн худалдан авах

авсаар байна. Олон улсын зах зээл дээрх газрын тосны үнэ тогтворжиж, хэт бага байсан инфляц сэргэж байгаа нь дэлхийн эдийн засаг эргэн сэргэх дохио болж байна. ЭЗХАБ-ын тоймд ирэх 2021 онд Евро бүсийн эдийн засаг 5.1%-иар, дэлхийн эдийн засаг 5.0%-иар өснө гэж таамаглаж байна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭРҮҮД

Улс орнуудын Төв банкууд мөнгөний бодлогын арга хэмжээг цаг алдалгүй авч, эдийн засгийн нөхцөл байдлаа дэмжих шаардлагатай юм. Учир нь Мөнгөний бодлогын үр нөлөө Сангийн бодлого шиг шууд гарахгүй, авч хэрэгжүүлж буй арга хэмжээнээс хамаарч 1-2, 3-4 улирлын дараа тухайн эдийн засагтаа нөлөөгөө үзүүлдэг. Энэ оны 9 дүгээр сард улс орнуудын Төв банкууд тус тусын шийдвэрээ гаргасан. АНУ-ын Холбооны нөөцийн сан /ХНС/ буюу Төв банк 9 сарын 16-ны өдрийн шийдвэрээр “Бодлогын хүүг 0-0,25



хувьд хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн. Энэ шийдвэрээ хөдөлмөрийн зах зээлийн байдал сайжирч, инфляц 2 хувьд хүрэх хүртэл хадгалж үлдэнэ” гэв. Түүнчлэн, ХНС-аас ирэх саруудад “зах зээлийн жигд ажиллагааг хангах, санхүүгийн таатай нөхцөлийг бүрдүүлэхэд туслах, ингэснээр айл өрх, ААН-үүдэд олгох зээлийн урсгалыг дэмжих” зорилгоор Засгийн газрын бонд, активаар баталгаажсан үнэт цаасыг цаашид үргэлжлүүлэн худалдан авахаар төлөвлөж байгаа аж. Дэлхийн хоёр дахь том эдийн засагтай орон болох Хятадын хувьд эдийн засаг нь үйлдвэрлэл болон экспортын нөлөөгөөр сэргэж байгаа боловч дотоод эрэлт нь удаашралтай хэвээр байна. Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний жилийн өсөлт энэ оны 8 дугаар сард 5,6%-д хүрсэн бөгөөд өргөн хэрэглээний бүтээгдэхүүний борлуулалтын өсөлт 2020 оны 1 дүгээр сараас хойш анх удаа эерэг дүнтэй

буюу 0,5% өсөлттэй байна. Хятадын Ардын банк энэ сарын шийдвэртээ 1 жилийн зээлийн суурь хүүг 3.85%, 5 жилийн зээлийн суурь хүүг 4.65% хувьд тус тус хэвээр үлдээлээ. Шинээр гарч буй ихэнх зээлүүд дээрх хүүд тулгуурлах бөгөөд 5 жилийн суурь хүү үл хөдлөх хөрөнгийн үнэ нэмэгдэхэд нөлөө үзүүлж байна. Шинжээчдийн хэлж байгаагаар АНУ-ын доллар суларч байгаа энэ үед Хятадын юань долларын эсрэг чангарч байна. Дэлхий нийтийн эдийн засгийн одоогийн эмзэг үед АНУ болон Хятадын харилцаа цаашид хэрхэх томоохон хүлээлтийг мөн үүсгэсэн хэвээр байна. Европын Төв банкны хувьд цар тахлаас үүдэлтэй эдийн засгийг дэмжих зайлшгүй шаардлага тулгараад байгаа. Инфляц 2%-д дөхөх хүртэл бодлогын хүүгээ хэвээр үлдээх шийдвэрийг гаргасан. Азийн томоохон төлөөлөл болох Японы Төв банкны хувьд богино

хугацааны бодлогын хүүг -0,1%, урт хугацааны хүүг 0% байхаар шийдвэрлэсэн. Ингэснээр эдийн засгийн идэвх болон үнийн өсөлтөөс шалтгаалсан өгөөж тодорхой түвшинд нэмэгдэнэ гэж тооцоолж байна. Манай улсын хойд хөрш болох ОХУ-ын Төв банкны 9 дүгээр сарын 18-ны өдрийн шийдвэрээр бодлогын хүүгээ жилийн 4,25%-д хэвээр хадгалахаар шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэрт цар тахлын хорио цээрийн дараах эрэлт нэмэгдэж, иргэд, аж ахуйн нэгжийн инфляцын хүлээлт сэргэсэн нь нөлөөлсөн байна. Монгол Улсын хувьд Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр хуралдан бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 8 хувьд хүргэх, урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх шийдвэр гаргасан. Энэхүү шийдвэр нь эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан үзээд банкны салбараас эдийн засгийн бодит секторт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэв.

үүрэг хүлээж байна. Иймд эдийн засгийг дэмжих бодлогоо үргэлжлүүлэн, сангийн бодлогыг хэт эрт хумихгүй байхад анхаарч, иргэдийг шинэ ажлын байраар хангах, хамгийн өндөр эрсдэлт бүлгийг анхаарах ёстой” гэж онцолсон. Ийнхүү дэлхий нийт цар тахалтай тэмцэж байна.

Эх сурвалж: Нэр дурдагдсан улс орнуудын Төв банкны 2020 оны 9 дүгээр сард гаргасан Мөнгөний бодлогын шийдвэрүүд Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын Дэлхийн эдийн засгийн Төлөвийн Тойм 2020/9/16

http://www.oecd.org/economic-outlook?fbclid=IwAR0V188yIFx6EQa55_v_eiWVG7bMPPvX2Ys4QXoYO59PFC_kRtzHP17g6d8#presentation

ЦААШИД ЮУНД АНХААРАХ

Цар тахлын нөхцөл байдал цаашид ямар байхыг хэн ч таамаглах боломжгүй байна. Гэвч дэлхий нийт ямар ч нөхцөл байдал тулгарсан урьдчилсан бэлэн байдлаа хангах нь аливаа эрсдэлийг бууруулах, хямралыг зөөллөх ач холбогдолтой гэдгийг баримталж арга хэмжээнүүдээ авч байна. Нэн тэргүүнд улс орнуудын хувьд эрүүл мэндийн салбарыг эрчимтэйгээр дэмжиж вирусын аливаа эрсдэлээс сэргийлэх шаардлагатай байна. Үүний тулд эрүүл мэндийн тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, эмч, ажилчдыг цалин, урамшууллаар хангах, иргэдийн эрүүл мэндийн халамжийг урьд урьдынхаас илүүтэй дээшлүүлэх хэрэгтэй байна. Мөн түүнчлэн хорио цээрийн улмаас бизнес нь зогсонги байдалд байгаа, үйл ажиллагаанд нь тодорхой хэмжээнд доголдол үүсч байгаа аж ахуйн нэгжүүд болон нийгмийн эмзэг бүлгийг дэмжих бодлогыг баримтлах нь чухал юм. Ингэснээр, царцсан эдийн засгийн тодорхой хэсгийг бага ч болов “бүлээн” байлгах нөхцөл бүрдэнэ. Эцэст нь ЭЗХАБ-аас гаргасан зөвлөмжид “Бодлого боловсруулагчдын хувьд эдийн засгийн нөхцөл байдлыг бүхэлд нь сэргээх томоохон

МОНГОЛ УЛСЫН 3 САЯ ДАХЬ ИРГЭНД ЗОРИУЛАН ГАРГАСАН ЗООС



Он: 2015

Нэрлэсэн үнэ: 5000 төгрөг

Металл: Зэс, мөнгө

Жин: 50 гр, голч 50 мм

Нүүр тал: “Монгол Улсын гурван сая дахь иргэн” гэж Монгол бичгээр, Кирилл үсгээр, Англиар тус тус бичсэн.

Дэлхийн бөмбөрцөг дээр Монгол Улсын газрын зургийг товойлгон, дээд талд нь морь унаж буй хүүхэд дүрсэлж, хажуу талд нь Соёмбо тэмдгийг байрлуулжээ. Доод талд нь 2015.01.28 гэж хагас дугуйруулан бичжээ.



ЖИЙН-ПАСКАЛ: ХҮНИЙ БОЛОН ИНСТИТУЦИЙН КАПИТАЛАА ТӨРӨЛЖҮҮЛЖ ЧАДААГҮЙ НЬ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОЛОН ЭКСПОРТЫН ТӨРӨЛЖИЛТ СУЛ БАЙХ ГОЛ ШАЛТГААН БОЛЖ БАЙНА

Дэлхийн банкны ахлах эдийн засагч ноён Жийн-Паскал Нгануг энэ удаагийн дугаартаа урьж ярилцлаа. Тус олон улсын санхүүгийн байгууллагаас Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн загварын тойм судалгаа хийснээ энэ сард танилцуулсан бөгөөд бид түүнтэй уг судалгааных нь талаар ярилцлаа.

Дэлхийн банкнаас Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн загварын тойм судалгаа хийснээ энэ сард олон нийтэд танилцуулсан. Судалгааны зорилго болон давтамж, өөр улс оронд хийгддэг тухай мэдээллээсээ хуваалцана уу.

Дэлхийн банкнаас гаргадаг “Улс орны эдийн засгийн үнэлгээ - The Country Economic Memorandum (CEM)” тайлан нь тухайн орны дунд хугацааны эдийн засгийн загвар, түүний төлөв, тэргүүлэх бодлогын чиглэлүүдийн хувьд мэргэжлийн үнэлгээ хийж, зөвлөмж өгөхийг зорьдог. Энэхүү тайлан нь Дэлхийн банкнаас гаргадаг томоохон тайлангуудын нэг юм. Тухайн орны Засгийн газартай эн тэргүүнд анхаарах салбарууд, эдийн засгийн асуудлуудаар санал солилцох, бусад донор болон тусалцаа үзүүлэгч орнуудад тухайн орны талаар мэдээлэл өгөхийг зорьдог. Уг тайлан нь ихэвчлэн 5-7 жилийн давтамжтай хийгддэг. Зарим орны хувьд 10 жил тутам хийгдэж ирсэн ч туршлага бий. Үүнээс гадна Дэлхийн банкнаас жил бүр “Монголын эдийн

засгийн тойм”-ыг гаргадаг. Энэ нь гол төлөв эдийн засгийн сүүлийн үеийн нөхцөл, байдалд түлхүү чиглэдэг төдийгүй тухайн цаг үеийн тодорхой сэдвүүдийг хөнддөгөөрөө онцлог гэж хэлж болно. Тухайлбал, сүүлийн 2 удаагийн тайланд улсын хөрөнгө оруулалтын удирдлага болон банкны салбарын зээлийн нөхцөл байдлыг тусгайлан хөндөж, дэлгэрэнгүй үнэлгээ хийн, зөвлөмж өгсөн байдаг.

Тайланг уншихад гол дүгнэлт нь хүний хөгжлийн асуудалд төвлөрсөн байсан. Нийгмийн баялгийн чухал суурь хүчин зүйл болсон хүний хөгжлийн асуудал орхигдож буйн үндсэн шалтгаан уг судалгаанд хэрхэн тайлбарлагдаж байна вэ?

Уг тайланд дурдагдсан гол асуудлуудын нэг нь Монгол улсын өнөөгийн уул, уурхайн салбарт түшиглэсэн эдийн засгийн загвар нь ирээдүйд тийм ч үр дүнтэй байж чадахгүйг сануулсан. Тодруулбал, одоогийн уул, уурхайд түшиглэсэн хөгжлийн загвар нь эдийн засгийн өсөлт, ядуурал зэрэг үзүүлэлтүүдэд зарим талаар эерэг өөрчлөлт авчирч байгаа ч нөгөө талдаа эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байгааг анхаарах хэрэгтэй. Монголын хувьд макро эдийн засаг богино давтамжтайгаар өндөр хэлбэлзэж байна. Мөн бизнесийн мөчлөгт өртөмтгий байдал нэмэгдсэн, эдийн засгийн өсөлтөд бүтээмжийн гүйцэтгэх үүрэг хангалттай

бус, мөн уул, уурхайн бус салбарт хангалттай цалинтай ажлын байр дутмаг байгаа, үүний зэрэгцээ институцийн чанар сул байгаа зэргийг дурдаж болох юм. Тэгэхээр Монголын одоогийн хөгжлийг уул, уурхай тодорхойлж байгаа ч ирээдүйд оюун ухаан буюу хүний болон институцийн хөгжил тодорхойлох нь зүйтэйг уг тайланд онцоллоо.

Бид потинциалаа бүрдүүлж чадахгүй байна уу, эсвэл байгаа мөртлөө бүрэн ашиглахгүй байна уу гэдэгт ямархуу дүр зураг харагдаж байна вэ?

Монгол Улсын хувьд хүмүүн капитал харьцангуй сайн байгаа бөгөөд орлогын хэмжээгээр дэлхийд 92-т, хүмүүн капиталын индексээр 51-д жагсаж байна. Энэ нь Монгол Улс мэдлэг, чадвартай болон эрүүл, дасан зохицох чадвартай хүний нөөцтэй бөгөөд энэ нь ирээдүйд бүтээмжээ өсгөх, уян хатан, инновацийг эрчимжүүлэх бүрэн боломжтойг илтгэж байна. Гэвч Монгол Улс эдийн засгийн хөгжилдөө хүмүүн капиталыг дутуу ашиглаж байгааг тус тайланд мөн цохон тэмдэглэсэн. Тиймээс энэ чиглэлд дорвитой шинэчлэл шаардлагатай гэсэн үг. Түүнчлэн институцийн чанар буюу жишээ нь авилгал, Засгийн газрын үйл ажиллагааны үр нөлөө болон хуулийн хэрэгжилт сүүлийн хэдэн арван жилд төдийлөн сайжраагүй байгаа нь ажиглагдсан. Дэлхийн банкнаас гаргасан 2014 оны засаглалын үзүүлэлтүүдээс харахад эдийн засгийн төстэй бүтэцтэй бөгөөд амжилттай хөгжиж буй орнуудтай харьцуулахад Монгол Улс засаглалын хөгжлөөрөө нэлээд хоцорч байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын эдийн засаг хүний болон институцийн хөгжлөөр бус биет баялгаар илүүтэй тэтгэгдэж ирснийг энд онцлох нь зүйтэй юм.

Тодруулбал, хөгжлийн ижил төстэй улсуудтай харьцуулахад манай улсын хүний хүчин зүйлээ ашиглаж буй байдал ямар түвшинд үнэлэгдэж байна вэ?

Ижил төстэй ойролцоо орнууд болох Армени, Колумб, Экаудор, Гайна, Казахстан, Перу болон ОХУ-тай харьцуулахад Монгол Улс эдийн засгийн хөгжилд хүмүүн капиталаа ашиглах тал дээр хоцорч байгаа. Доорх зураг дээрх орнууд үйлдвэрлэлийн хүчин зүйл (байгалийн баялаг болон хүний хүчин зүйл)-ээ хэрхэн өөрийн эдийн засгийн хөгжилдөө ашиглаж байгааг

харуулсан. Зургаас ажиглахад бусад ижил төстэй орнууд байгалийн баялгаас илүүтэй хүмүүн капиталаа эдийн засгийн хөгжилд түлхүү ашиглаж байгааг харж болох юм.

Зураг: Үйлдвэрлэлд ашиглаж байгаа хүний болон байгалийн баялгийн хүчин зүйлс: Монгол болон бусад эдийн засгийн бүтцийн хувьд ижил төстэй орнууд



Тэгэхээр эдийн засгийн төрөлжилтөд энэ нь маш хамаатай асуудал шүү дээ. Та бүхэн ямар дүгнэлтэд хүрсэн бэ?

Санал нэг байна. Энэ нь яах аргагүй эдийн засгийн төрөлжилтийн суурь асуудал юм. Уг тайланд бид Монгол Улс өөрт өгөгдсөн суурь баялаг болох хүний болон институцийн капиталаа төдийлөн төрөлжүүлж чадаагүй нь бүтээгдэхүүний болон экспортын төрөлжилт сул байх гол шалтгаан байгааг онцолсон. Тайланд дурдсанчлан өгөгдсөн суурь баялгийн төрөлжилт нь бүтээгдэхүүн болон экспортын төрөлжилттэй эерэг хамааралтай байдгийг бусад орны туршлага харуулдаг. Өөрөөр хэлбэл, өгөгдсөн баялгаа буюу биет капитал, байгалийн баялаг, хүний болон институцийн капиталаа хэдий сайн төрөлжүүлж чадна төдий чинээ экспортын төвлөрөл бага, бүтээгдэхүүний төрөлжилт сайтай байдаг гэх дүгнэлт хийж болох юм.

Бас зайлшгүй хөндөх дараагийн сэдэв бол уул уурхайгаас хамаарсан эдийн засгийн орлого нь манай улсад өгөөж болж чадаж байна уу үгүй юу гэдэгт бид анхаарах шаардлага бий. Өөрөөр хэлбэл үүнээс төвлөрүүлсэн хуримтлал

хангалтгүй байгаагийн сөрөг үр дагаварыг хэрхэн анхааруулах вэ?

Хуримтлал бол эдийн засгийн хөгжлийн гол тулгуур үзүүлэлт бөгөөд энэ нь хөрөнгө оруулалтыг санхүүжүүлж, өр үүсгэхээс сэргийлдэг. Байгалийн баялаг ихтэй орнуудад нэг ажиглагддаг зүйл нь уул, уурхайн орлогоосоо хангалттай хэмжээний хуримтлал хийж чадахгүй байхын хэрээр тухайн улсын макро эдийн засаг хэлбэлзэл өндөртэй байх явдал юм. Хамгийн гол нь энэ нь өрхийн хэрэглээг савлуулах, улмаар сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Энэ хүрээнд улс орнууд иргэд болон өрхүүдийнхээ одоо болон ирээдүйн хэрэглээг тогтворжуулах үүднээс хуримтлалын санг үр дүнтэй ашиглаж чадвал цаашид “Голланд өвчин”-д нэрвэгдэх магадлалыг бууруулж, ханшийн хэлбэлзлийг сааруулдаг.

Тэгвэл өнөөгийн нөхцөл байдлаас үзэхэд бодлогын тэргүүлэх чиглэл юу байх талаар ямар зөвлөмж өгч байна вэ?

Бодлогын тэргүүлэх чиглэлийн хувьд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, мөчлөг сөрсөн төсөв, мөнгөний бодлого хэрэгжүүлэх, төсвийн тогтворжуулалтын санг үр дүнтэй ажиллуулах зэргийг дурдаж болно. Мөн уг тайланд бид Засгийн газар одоогийн өндөр түвшний өрийн менежментээ хийхэд төсвийн тогтворжуулалтын болон ирээдүйн өв сангийн хуримтлалыг зөв зохистой хослуулан ашиглах нь зүйтэйг сануулсан. Өр өндөр байх нь Монгол Улс олон улсын санхүүгийн захаас хөрөнгө татахад хүндрэл учирч болзошгүйг санах хэрэгтэй юм.

Бодлогын институциудын хараат бус байдлын асуудал энэ тайланд хөндөгдсөн байсан шүү дээ. Одоогийн түвшнийг хэрхэн үнэлж байна вэ?

Дээр дурдсанчлан мөчлөг сөрсөн төсөв, мөнгөний бодлого, төсвийн тогтворжуулалтын сангийн үйл ажиллагааг сайжруулах явдал нь яахын аргагүй институцийн хөгжлийн нэг хэсэг болох Төв банкны бие даасан байдал болон бие даасан төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үр дүнтэй үйл ажиллагаанаас ихээхэн хамаарна. Өнөөдөр төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь УИХ-ын байнгын хорооны дор

байгуулагдсан байгаа нь уг зөвлөлийн бие даасан байдал хэр хэмжээнд байна вэ гэдэг эргэлзээг төрүүлдэг. Олон улсын туршлагаас харахад төсвийн тогтвортой байдлын зөвлөл үр дүнтэй ажиллах нэг суурь асуудал нь түүний бие даасан байдал юм. Төв банкны тухай хуулинд 2018 онд нэмэлт өөрчлөлт оруулж Төв банкны бие даасан байдал тодорхой хэмжээнд сайжирсан ч цаашид дахин сайжруулах шаардлага байсаар байна. Тухайлбал, 2020 оны эхэнд тэтгэврийн зээлийг тэглэсэн зэрэг хэд хэдэн арга хэмжээнүүд нь Төв банкны бие даасан байдлыг сайтар эргэн харах шаардлагатайг илтгэсээр байна.

Өдгөө Төв банкнаас хэрэгжүүлж буй мөнгөний бодлогын шийдвэрүүд Дэлхийн банкнаас өгч буй бодлогын зөвлөмжтэй хэрхэн нийцтэй байна гэж үзэж байна вэ?

Сүүлийн 2 жилийн хугацаанд мөнгөний бодлогын хэрэгжилт нь ерөнхийдөө үр дүнтэй байна гэж хэлж болохоор байгаа ба үүнийг сүүлийн жилүүдэд инфляц Төв банкны дунд хугацааны зорилтот түвшинд хадгалагдсаар байгаагаар холбон тайлбарлахаар байна. Хэдий улсын гадаад валютын нөөц 2016 оноос хойш сайжирч байгаа ч гадаад шокийн эсрэг тийм ч хангалттай хэмжээнд биш байна. Түүнчлэн бодит ханшийн чангаралтаас сэргийлэхийн тулд төгрөгийн ханшийг аль болох уян хатан байхад анхаарч, гадаад валютын интервенцээ тодорхой хэмжээнд хязгаарлах нь зүйтэй. Үүний зэрэгцээ инфляцыг зорилтот түвшинд байлгахад голлон анхаарч, гадаад секторын тэнцвэрийг хангахад анхаарлаа тууштай хандуулах нь зүйтэй.

Бусад анхаарах бодлогын асуудлуудын хувьд ямар зөвлөмж өгөх вэ?

Макро зохистой бодлогоор долларжилтийг бууруулах, гадаад валютаарх өрийн дарамтыг бууруулахад анхаарч улсын өрийн менежмент нь улсын өр доторх гадаад валютаарх өрийн хэмжээг шат дараатай бууруулахад мөн анхаарах нь зөв болов уу. Үүний зэрэгцээ дотоодын бондын зах зээлийн хөгжлийг гүнзгийрүүлэх мөн чухал юм. Төсвийн бодлого нь тогтвортой байдалд илүү анхаарч, төсвийн тогтворжуулалтын болон ирээдүйн өв сангуудын хуримтлалаар дамжуулан урт хугацааны тогтвортой байдалд тууштай чиглэх нь зүйтэй.

ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Д.Оюунцэцэг¹, Н.Болдмаа², П.Баянсан³

1. Иргэдийн санхүүгийн мэдлэг, боловсролын тухай ойлголт

Иргэн бүр санхүүгийн оновчтой шийдвэр гаргахад шаардлагатай мэдлэг, чадварт суралцаж зөв дадал эзэмших нь тухайн хувь хүн, өрхийн аж байдал төдийгүй, улс орны санхүүгийн салбарын тогтвортой хөгжлийн нэгэн чухал үндэс болдог. Эрдэмтдийн хийсэн судалгаагаар хөгжингүй орнуудад хувь хүний орлого ойролцоогоор ДНБ-ий 70 орчим хувийг бүрдүүлдэг байна. Иймээс улс орны санхүүгийн тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг нь хувь хүний санхүү байдаг. Мөн санхүүгийн боловсрол бол өрх бүрт санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, амьжиргааг сайжруулах урьдач нөхцөл мөн. Учир нь санхүүгийн боловсролтой иргэн мөнгө хадгалах, хуримтлуулах, хөрөнгө оруулалт хийх болон зээл авахдаа судалгаа, тооцоо хийсний үндсэн дээр зөв шийдвэр гаргаж чаддаг.

Зураг 1. Санхүүгийн мэдлэг, чадвар, хандлага

МЭДЛЭГ/KNOWLEDGE	ЧАДВАР/SKILLS	ХАНДЛАГА/ATTITUDE
- Хувийн санхүүгийн төлөвлөлт - Хөрөнгө оруулалт - Санхүүжилт - Хадгаламж, хуримтлал - Зээл - Эрсдэл - Даатгал - Хувьцаа, бонд - Санхүүгийн луйвар, залилан - Тэтгэвэр - Бусад	- Санхүүгийн таамаглал хийх - Өгөөж, эрсдэлийг тооцох - Төсөв, төлөвлөгөө зохиох - Мөнгөний үнэ цэнийг тооцох - Инфляци болон валютын ханшийн нөлөөлөл тооцох - Хэрэгцээндээ тохируулж санхүүгийн бүтээгдэхүүнээс сонголт хийх - Хүү, өсөлт тооцох	- Төлөвлөгөөтэй зарцуулах болох - Ухаалаг хэрэглэгч байх - Хуримтлалыг аль болох эртнээс үүсгэхийг эрмэлзэх - Эрсдэл зайлшгүйг ойлгож түүнээс урьдчилан сэргийлэх - Судалгаанд суурилж шийдвэр гаргах - Санхүүгийн үйлчилгээг харьцуулсны үндсэн дээр сонгох

Эх сурвалж: Баянсан П., Б. О. (2018). Даяаршлын эриний дээд боловсрол, хэл шинжлэл, соёлын харьцуулсан судалгаа, ОУЭШБХ. Санхүүгийн боловсролыг дээшлүүлэх боломж, арга зам. Улаанбаатар.

¹ ХҮИС-ийн багш, доктор (Ph.D.).
Цахим шуудан: Yalguulagch_xzx@yahoo.com

² ХҮИС-ийн багш, доктор (Ph.D.).
Цахим шуудан: boldmaa.na@gmail.com

³ ХҮИС-ийн багш, магистр (MBA).
Цахим шуудан: Bayansan-fin_dep2007@yahoo.com

Өөрөөр хэлбэл, санхүүгийн мэдлэг нь эдийн засгийн нөхцөл байдалд тохирсон санхүүгийн үр ашигтай шийдвэр гаргах, санхүүгийн эрсдэлээс зайлсхийх зэргээр хувь хүний нас, хүйс, боловсрол, орлогын түвшнээс үл хамаарч насан туршид хэрэглэгдэх үнэт зүйл юм. Санхүүгийн мэдлэгийг энгийнээр тодорхойлбол, мөнгөө хэрхэн зөв удирдах тухай мэдлэг юм. Санхүүгийн мэдлэгтэй болсноор хадгаламж ба хуримтлал, өр ба зээлийн ялгааг ойлгож, санхүүгийн зөв шийдвэр гаргаж, орлогоо нэмэгдүүлж, зардлаа хэмнэж, хувийн санхүүгээ төлөвлөж, өрхийн санхүүгээ эрүүлжүүлж чадна. Санхүүгийн мэдлэг бол бүх насныханд хамааралтай, насан туршийн үйл ажиллагаа байдаг.


2. Иргэдийн санхүүгийн мэдлэг, ойлголтын түвшний судалгаа

Дэлхийн банкнаас 2012 онд Монгол Улсын санхүүгийн байгууллагын харилцагчийн эрх ашгийн хамгаалалт болон тэдний эдийн засаг, санхүүгийн мэдлэг, боловсролын байдлыг олон улсын түвшинтэй харьцуулсан судалгаа хийжээ. Уг судалгаагаар хөдөө орон нутагт ажиллаж амьдардаг малчид ирээдүйд зориулсан хуримтлал, тэтгэврийн төлөвлөлтийн ач холбогдол, зорилгогүй зээл авахын сөрөг үр дагавар болон өөрт хэрэгцээтэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс зөв сонголт хийх талаар мэдлэг муутай байгааг тогтоожээ. Түүнчлэн судлаач Д.Эрдэнэбилэгийн хийсэн судалгаанд оролцогчдын 36 хувь нь өөрийн санхүүгийн мэдлэгээ дээшлүүлэх маш чухал шаардлагатай гэж үзсэнээс үзэхэд, хөтөлбөр хэрэгжихээс өмнө манай орны иргэдийн санхүүгийн мэдлэг туйлын хангалтгүй байсан ажээ.

Аливаа мэдлэгийг олгохын тулд үр дүнд суурилсан сургалт чухал болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, үүнд чиглэсэн олон алхмыг хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгчид ч зорилтот бүлэгт чиглэсэн сургалтын үр дүнд иргэдийн ойлголт, мэдлэг, хандлага өөрчлөгдөн, санхүүгийн чадавх дээшилнэ гэж үзсэн байна. Иймээс ч хөтөлбөрийн хүрээнд хөдөө, орон нутгийн иргэд, олон нийтэд чиглэсэн сургалтыг зохион байгуулж, нийт 23.0 мянга шахам иргэнийг хамруулан зохих үр дүнд хүрч байна. Бид энэхүү судалгаагаар сургалтад хамрагдсан иргэдийн сургалтаас олж авсан санхүүгийн мэдлэг, хандлагыг асуулгын аргаар үнэллээ. Судалгаанд нийслэл, 15 аймгийн 16-70 насны 140 иргэн хамрагдсанаас 39.3 хувь нь эрэгтэй, 60.7 хувь нь эмэгтэй байлаа.


Зураг 2. Судалгаанд хамрагдсан иргэд (газарзүйн байршил, хувиар)



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан иргэдийн санхүүгийн мэдээллийн эх сурвалжийг судалж үзэхэд, хэвлэл мэдээллийн хэрэгслээс 39.3 хувь, насан туршийн боловсролын төвөөс 17.5 хувь, сургуулийн багшаас 16.9 хувь, сурах бичиг, гарын авлагаас 13.7 хувь, хэвлэл, мэдээллийн хэрэгслээс 39.3 хувь нь авснаас үзэхэд, хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашиглан санхүүгийн мэдлэг, мэдээллийг хүргэх нь илүү үр дүнтэй болох нь харагдаж байна.

Зураг 3. Иргэдийн санхүүгийн мэдээллийн эх сурвалж




Эх сурвалж: Судалгааны үр дүн

Судалгаанд оролцогчдын сургалтаар олж авсан санхүүгийн мэдлэгийн түвшинг нийт 11 сэдвийн хүрээнд дараах шалгуураар, дөрвөн онооны системээр үнэлсэн болно. Үүнд:

1. Огт ойлгоогүй, үр дүнгүй байсан;
1. Заримыг нь ойлгосон;
2. Ихэнхийг нь ойлгож, мэдэж авсан;
3. Бүрэн мэдлэг, ойлголттой болсон.

Судалгаагаар дараах үр дүнг зураг 4-өөс харахад, судалгаанд оролцогчид нийт 11 сэдвийн хүрээнд мэдлэг олж авсан бөгөөд дунджаар (давхардсан тоогоор) сэдвээр олгосон мэдлэгийн 62.8 хувийг эзэмшсэн гэж өөрсдийгөө үнэлжээ. Сэдэв тус бүрээр авч үзвэл, тэдний амьдралд хамгийн ойр байдаг мөнгө, өрхийн төсөв, хуримтлал ба хадгаламж гэсэн сэдвийн талаар илүү мэдлэг, ойлголттой болсон байна. Харин тэтгэврийн талаар хамгийн бага буюу 53.0 хувь нь мэдлэг олж авсан нь 2012 онд Дэлхийн банкнаас хийсэн судалгаанд оролцогчдын 57 хувь нь ирээдүйгээс илүү одоо байгаа нөхцөл байдалд илүү анхаарлаа хандуулдаг гэсэн дүгнэлтийг баталж байгаа юм. Өөрөөр хэлбэл, ирээдүйн тэтгэврийн асуудлаас илүүтэй зөвхөн өнөөдрийн санхүүгийн асуудалд анхаарч байгаа нь уг сэдвийг ойлгож авахад хүндрэл үүсгэсэн байж болох талтай юм. Түүнчлэн иргэдэд хуримтлуулах дадал, хандлага бүрэн төлөвшөөгүйгээс хадгаламжийн хэмжээ бага, үүнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалтын талаар сонирхдоггүй, энэ талаарх мэдлэгийн түвшин хангалтгүй байгаа нь ажиглагдлаа.

Зураг 4. Иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин




Эх сурвалж: Судалгааны үр дүн

Сургалтад суусан иргэдийн хандлагын өөрчлөлтийг асуулгын аргаар судаллаа. Зураг 5-аас харахад,

судалгаанд хамрагдсан иргэдийн 17 хувь нь (давхардсан тоогоор) өрхийн төсөв зохиож хэрэгжүүлэхийг, 15 хувь нь зээлээ хугацаанд нь төлөхийг эрмэлздэг болсон гэж хариулжээ.

Зураг 5. Иргэдийн хандлагын өөрчлөлт, хувиар




Эх сурвалж: Судалгааны үр дүн

Тэдний гурван хувь нь валютын ханшийн өөрчлөлтийг судалж, санхүүгийн шийдвэр гаргахдаа харгалзан үзэхийг эрмэлздэг болсон нь хамгийн бага үзүүлэлт болж байгаагийн шалтгаан нь валютаар гүйлгээ хийх хэрэгцээ шаардлага тэр бүр гардаггүйтэй холбоотой байж болох юм.

Сургалтын үр дүнд иргэд өөрийн санхүүгээ удирдахад шаардлагатай зохих чадварыг эзэмшсэн байна. Тухайлбал, судалгаанд хамрагдагсдын 57.6 хувь нь санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг өөрийн хэрэгцээ, нөхцөл байдалд тулгуурлан сонгох чадвартай болсон гэж хариулсан бол 10.4 хувь нь татварын тайлан гаргах чадварт суралцжээ.

Зураг 6. Иргэдийн эзэмшсэн чадвар, хувиар




Эх сурвалж: Судалгааны үр дүн

Судалгааны үр дүнгээс үзэхэд, хөрөнгө оруулалтын эрсдэл, өгөөжийг тооцох, татварын тайлан гаргах, татвар тооцох чадвар эзэмшсэн иргэдийн хувийн жин

бага байна. Энэ нь нэг талаас иргэдэд уг чадварт суралцах хэрэгцээ шаардлага бага, нөгөө талаас тооцоолол ихтэй, цогц үйл ажиллагаа байдаг тул нэг удаагийн сургалтаар уг чадварыг эзэмшихэд хүндрэлтэй байдагтай холбоотой гэж дүгнэж байна.

Зураг 7. Судалгаанд оролцсон иргэдийн сургалтаар олж авсан мэдлэг, чадвар, хандлагын дундаж хувь



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Судалгааны үр дүнг нэгтгэн үзэхэд, "Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж, иргэдэд санхүүгийн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсны үр дүнд олон нийтийн санхүүгийн мэдлэг, чадвар, хандлагад ахиц гарсан байна. Дунджаар (давхардсан тоогоор) судалгаанд хамрагдсан иргэдийн 31 хувь нь тодорхой мэдлэг олж авсан бол 23.4 хувь нь санхүүгийн шийдвэр гаргах, санхүүгээ удирдахад шаардлагатай чадвар эзэмшиж, 21.6 хувь нь зөв хандлагатай болжээ. Уг үзүүлэлтийг Дэлхийн банкнаас 2012 онд хийсэн судалгааны дүгнэлттэй харьцуулахад иргэд ирээдүйд зориулсан хуримтлалын ач холбогдлыг ойлгож, хуримтал хадгаламж хийх эрмэлзэлтэй болсон төдийгүй тэдний 57.6 хувь нь өөрт хэрэгтэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс зөв сонголт хийх чадвартай болсон байна.

Иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэхийн тулд дараах зүйлд анхаарах шаардлагатай юм. Үүнд:

- Кейс жишээн дээр тулгуурлан сургалтыг зохион байгуулах;
- Цахим сүлжээ, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан мэдлэг түгээх;
- Татвар, даатгал, хувьцаа, бондын арилжааны талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх;
- Хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг түлхүү өгөх;
- Тэтгэврийн төлөвлөлт, тооцоолол хийхийн ач холбогдлыг бүрэн ойлгуулах.



ХУРИМТЛАЛ Ба ХАДГАЛАМЖ

ЯАГААД БИД ХУРИМТЛАЛТАЙ БОЛОХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

Бидний амьдралд урт, богино хугацааны төлөвлөж болох, төлөвлөж болохгүй бэлэн мөнгөний хэрэгцээ шаардлага гардаг. Энэ үед нэг бол хуримтлалаараа, эсвэл зээл авах, эд хөрөнгөө худалдах байдлаар зохицуулах шаардлагатай болдог.

Мэдээж хамгийн сонгодог арга нь мөнгөн хуримтлалаараа гэнэтийн мөнгөний хэрэгцээгээ хангах явдал юм. Өөрөөр хэлбэл, зээл авбал та зээлийн хүү төлөх хэрэгтэй болно. Эд хөрөнгө зарж борлуулан богино хугацаанд бэлэн мөнгөтэй болохын тулд магадгүй зах зээлийн үнээс хямдаар зарахаас аргагүйд хүрнэ. Иймээс гэнэтийн хэрэгцээ шаардлагад бэлэн байх, хэтийн хүсэл, зорилгодоо хүрэхэд хуримтлал чухал.

ХЭРХЭН ХАДГАЛАМЖТАЙ БОЛОХ ВЭ?

Хадгаламж нь таны зорилго, мөрөөдөлтэй холбогдвол илүү үр дүнтэй болно. Иймд мөрөөдөл, зорилгодоо хүрэхийн тулд хуримтлалынхаа төлөвлөгөөг гаргаж түүнд тууштай, санхүүгийн сахилгатай байх нь чухал.

ХАДГАЛАМЖИЙН ЗОРИУЛАЛТ

- Орон сууц худалдан авах
- Автомашин худалдан авах

- Баяр ёслол хийх, бэлэг худалдан авах
- Эрүүл мэндийн асуудал үүсэх
- Орон сууц, автомашины засвар
- Ирээдүйн санхүүгийн хамгаалалт /ажлаасаа гарах, тэтгэвэрт гарах /

ХУРИМТЛАЛ ҮҮСГЭХ АЛХМУУД

1. Орлого ба зардлаа бүртгэх
2. Хэмнэж болох зардлыг хасч орлого, зардлын төлөвлөгөө гаргах
3. Хуримтлал хийж болох хэмжээг тодорхойлох
4. Хуримтлал хийх зорилгоо ач холбогдлоор нь жагсаан бичих
5. Урт, богино хугацааны хуримтлалын зорилгоос хамааруулан хуримтлалынхаа хэлбэрийг сонгох
6. Хуримтлалаа эхлүүлж, хэрхэн өсч байгааг хянаж байх

ХАДГАЛАМЖИЙН ҮНДСЭН 2 ТӨРӨЛ

- Хугацаатай хадгаламж
- Хугацаагүй хадгаламж

ХУГАЦААТАЙ ХАДГАЛАМЖ

- Хэрэв та тодорхой зорилготойгоор хуримтлуулах, мөнгөнийхөө хэрэгцээг хугацааны хувьд төлөвлөх боломжтой бол хугацаатай хадгаламжийг сонгох нь ашигтай.

- 1,3,6,12 сар болон түүнээс дээш хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүн банкууд санал болгодог. Энэ нь хугацаагүй хадгаламжтай харьцуулахад өндөр хүүтэй байдаг.
- Хадгаламжийн сертификат нь хугацаатай хадгаламжаас өндөр хүү төлдөг хатуу нөхцөлтэй бүтээгдэхүүний нэг юм.

ХУГАЦААГҮЙ ХАДГАЛАМЖ

- Та мөнгөө богино хугацаанд ашиглахаар төсөвлөсөн эсвэл гэнэтийн зардалд зарцуулахаар төлөвлөсөн бол хугацаагүй хадгаламжийг сонгох нь ашигтай.
- Өдөр тутмын төлбөр тооцоо төлөхөд ашиглах хүүгүй эсвэл маш бага хүүтэй байдаг (харилцах данс).
Дээрх нийтлэг хадгаламжийн төрлөөс гадна хүүний төлбөрийг хэдий хугацаанд ямар давтамжтайгаар өгч байгаагаас хамаарсан хадгаламжийн бүтээгдэхүүнүүд байдаг. Тухайлбал:

УРЬДЧИЛСАН ХҮҮТ ХАДГАЛАМЖ

- Хадгаламж нээлгэсэн даруй эсвэл сар бүр харилцах дансандаа авах хадгаламж юм. Хүссэн цагтаа орлого хийж болох ч данснаасаа хугацаанаас өмнө мөнгө авах бол хүүг бууруулсан хүүгээр тооцдог.

ХҮҮНЭЭС ХҮҮ ТООЦОХ ХАДГАЛАМЖ

- Сар бүрийн эцэст хуримтлагдсан хүүг тухайн хадгаламжийн дансанд шилжүүлэн хүүнээс хүү тооцдоггоороо онцлог.

ХАДГАЛАМЖИЙН ХҮҮНИЙ ТӨРЛҮҮД

- Харилцах
- Хугацаагүй хадгаламж
- Энгийн хугацаатай хадгаламж
- Хүүгээ сар бүр олгох урьдчилсан хүүт хадгаламж
- Хүүнээс хүү тооцох хадгаламж
- Хадгаламжийн сертификат

БАНК ДАМПУУРСАН ТОХИОЛДОЛД ЯАХ ВЭ?

Арилжааны банк нь хадгаламж эзэмшигчдийн мөнгөн хөрөнгийг заавал даатгуулах хуулийн үүрэг хүлээдэг. Банк дампуурсан тохиолдолд хуулиараа таны хадгалуулсан 20.0 хүртэл сая төгрөг эсвэл түүнтэй тэнцэх

хэмжээний валютын хадгаламжийг нөхөн олгохоор “Банкин дахь Мөнгөн хадгаламжийн даатгалын тухай” хуульд заасан байдаг.

ХАДГАЛАМЖИЙН ХҮҮГ ХЭРХЭН ТООЦДОГ ВЭ?

Энгийн хадгаламж

Хадгаламжийн дүн = Анхны мөнгөн дүн $\times (1 + \text{хүү})^{\text{жил}}$

Хүүнээс хүү бодох хадгаламж

Хадгаламжийн дүн =

Анхны мөнгөн дүн $\times (1 + \frac{\text{жилийн хүү}}{12})^{(\text{жил} \times 12)}$

Сар бүр тодорхой дүнгээр тогтмол дүнгээр хуримтлал үүсгэх хадгаламж

Хадгаламжийн дүн =

Сар бүрийн хуримтлалын дүн $\times \frac{(1 + \text{жилийн хүү}/12)^{\text{жил} \times 12}}{\text{жилийн хүү}/12}$

ХАДГАЛАМЖИНД ИНФЛЯЦ ЯАЖ НӨЛӨӨЛДӨГ ВЭ?

Инфляц бидний худалдан авалтад нөлөөлөхөөс гадна хадгаламжийн орлогод нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, инфляц хэдий чинээ их байна, хадгаламжийн хүүнээс олох орлогыг бас бууруулж байдаг.

Хадгаламжийн бодит хүү = Хадгаламжийн нэрлэсэн хүү – Инфляцын хувь

Тиймээс бодит хүү гэдэг нь инфляцыг тооцсон хүү юм.

